



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

*2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 35

---

- 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/* 5 - 35
- 2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 35

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 17-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Б.Баярсайхан, С.Одонтуяа, Ж.Чинбүрэн.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал Х.Баасанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, М.Оюунчимэг, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, Д.Батлут нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар нар хариулж, тайлбар хийв.

**П.Анужин:** Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

***Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал Х.Баасанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 33 минут үргэлжилж, 17 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 76.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 48 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА**

**П.АНУЖИН**

**Тэмдэглэл хөтөлсөн:**

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,

Лхагва гараг

Төрийн ордны “Их засаг” танхим

12 цаг 15 минут

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**П.Анужин:** Байнгын хорооны нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдааны эхэнд ер нь гишүүдэд сануулахад чухал биш Байнгын хороо гэж мэдээж байхгүй. Тэгэхдээ тэр дундаа нийгмийн асуудлыг, өдөр бүр иргэдийн амьдралд тулгамддаг гол чухал асуудлуудыг л бид энэ Байнгын хороогоор хэлэлцдэг.

Тэгээд хуралдаа хоцорч ирж байгаа, бусдынхаа эрх ашгийг хөндөж хуралдааныг үргэлж хоцруулж байгаа гишүүдийн нэрсийг дараагийн хуралдаанаас зарлана.

Улсын Их Хурал нийгэмд гишүүдийн оролцоо идэвхийг ил тод байлгах талаар Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурал дээр анхааруулж байсныг Та бүхэн мэдэж байгаа.

Ер нь тэгээд эмх цэгцтэй байхын эхлэл бол ирц. Цагтаа байх гэдгийг Та бүхэн хэлүүлэхгүй мэдэж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг би Та бүхэндээ танилцуулъя.

П.Анужин ирсэн байна, Д.Батлут гишүүн ирсэн, Б.Бейсен гишүүн ирсэн байна, Б.Жаргалмаа гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, С.Чинзориг гишүүн ирсэн, Ц.Идэрбат гишүүн ирсэн, Б.Саранчимэг нарын гишүүд хуралдаандаа ирсэн байна.

Нэгэнт ирц хөндсөнийх үргэлж, бараг цагаасаа хоцроогүй Б.Жаргалмаа гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Ц.Идэрбат гишүүн, Д.Батлут гишүүн гэсэн Байнгын хорооны хуралдаа ерөөсөө 1 минутын хоцролгүй суудаг гишүүддээ талархаж байгаагаа илэрхийлье. Энэ сайн үзүүлэлт гэж бодож байна.

Ирцээ танилцууллаа Та бүхэнд.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл.

Монгол Улсын Засгийн газар мөн 2023 оны 05 сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

*Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл  
/Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
хоёр дахь хэлэлцүүлэг/*

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцье.

Ажлын хэсгийн гишүүдийг Та бүхэндээ танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүдийг хуралдааны танхимд оруулъя.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг Та бүхэндээ танилцуулъя.

Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэрэмийн Цолмон. Д.Цолмон ирсэн үү? Хууль зүйн яамныхан ирж байгаа юм уу? Тэгвэл Д.Цолмон ирээгүй байна. Нинжбатын Ууганбаатар Монгол Улсын Их Сургуулийн шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор, Хүрэлбаатарын Баасанжаргал Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн хэлэлцүүлэг эхлэхийн өмнө холбогдох хуулийн заалтуудыг Байнгын хорооны гишүүд Та бүхэндээ уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол

Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ гаргана.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Даваажанцангийн Сарангэрэл гишүүнээр тасалж байна.

Асуулт асуухын өмнө би нэг зүйлийг танилцуулъя. Та бүхэнд дараах зүйлийг танилцуулъя.

Улсын Их Хуралд Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу 46.4-д Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хороо хэлэлцүүлэхэд гишүүний асуулт асуух хугацаа 8 минутаас илүүгүй. Нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй. Гишүүний асуултад хариулах хугацаа 8 минутаас илүүгүй. Нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байна гэж заасан байгаа.

49.2-т Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж болно гэж заасан байгаа.

Нэрсийн дарааллын дагуу гишүүд асуултаа асууя. Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофонд урьж байна.

**С.Ганбаатар:** Үндсэн хуулийн асуудлаар Улсын Их Хурлын чуулган дээр би байр сууриа их тодорхой хэлсэн байгаа.

Ард иргэдийн амьжиргаа, хүнд байдал, юмны үнэ, ажлын байр. Биднийг ажлын байр нэмэгдүүлээрэй, амьдралыг минь өөд нь авч яваарай гэж сонгосон болохоос биш сандал, ширээгээ хамгийн түрүүнд яриарай гэж сонгоогүй.

Тэгээд энэ утгаараа цаг нь болоогүй байна. Энэ асуудлыг нь би өнөөдөр нэгэнт л хоёрдугаар хэлэлцүүлгээр яг энэ асуудалтай нь холбогдуулж ярихгүйгээр ядаж ард нийтийн санал асуулга явуулах арга замыг нь та нар минь дэмжээд өгөөч ээ. Үүнийг л би ярьж байгаа шүү дээ. Улсын Их Хурлын чуулган дээр ч ярьсан.

Өнөөдөр бид ард түмнийг төлөөлж байгаа төлөөлөл болохоос биш өөрсдийгөө Үндсэн хуулийн эзэн гэж өөрсдөө бодож болохгүй. Үндсэн хууль бол нийт ард түмний нийгмийн гэрээ гэж байгаа шүү дээ. Хоорондоо гэрээ. Төртэй байгуулдаг гэрээ ч гэдэг буруу шүү. Төр харин үүнийг нь хэрэгжүүлнэ.

Тэгэхээр тэр ард түмний эзэн эрхэд нь бид халдаад байна.

Тэгээд миний хэлэх гээд байгаа санаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 5.4.6-д заасан төслийн хэлэлцүүлгийн үе шатад Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллаад санаа бодлыг нь судалж, таслал тавиад “харгалзан үзэх” гэж байгаа шүү.

Өнөөдөр бид харгалзан үзсэн үү? Миний асуулт. Нийт ард иргэд 99 хувь нь эсрэг байна. Зарим гишүүдийн хамаатнууд л дэмжиж байж магадгүй.

Тэгэхээр чуулган дээр орж ирээд 99 хувь нь энэ ерөөсөө ард түмэн туйлаас дэмжиж байна гэдэг юм ярина гэдэг бол энэ Улсын Их Хурал ард түмнээсээ тасарчихсан байна гэсэн үг.

Хоёрдугаарт, “харгалзан үзнэ” гэж байгаа шүү. Яаж харгалзаж байгаа вэ?

152-ыг эсэргүүцэж байна. Тэгэхээр 158 болж таарна гэж хүмүүсийн өмнө онигоонд бид орж болохгүй шүү.

152-ыг эсэргүүцэж байна. 126 байхад болно гэж үзэж байна гэж муйхарлаж болохгүй шүү.

Бүр 76 чинь ч ихдэж байна гэж яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр би үүнийг тэр онолын хувьд 76 нь зөв, 108 нь зөв, 120 нь зөв гэж ярих гээгүй ээ.

Зүгээр л ард түмний бүрэн эрхэд нь халдахгүйгээр нийтийн санал асуулга явуулах боломж байна уу?

Хоёрдугаар хэлэлцүүлгийн үед ярина шүү гэж надад хэлсэн. Яг би Улсын Их Хурлын чуулганаар ярьж байхад надад ингэж хэлсэн. Хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр ярьдаг юм.

Хоёрт нь, нийгмийн сүлжээн дэх мэдээллийн тоймоос үзэхэд 152-ыг нь татгалзсан гээд байгаа. Энэ 126-г дэмжсэн гэсэн үг биш шүү. 124 ч билүү. Одоо та нар тоо тогтоогоод байгаа шүү дээ гэсэн үг биш ээ.

Үндсэн хуулийн 25.1-д Улсын Их Хурал дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэхээд 25.1.1-д нь хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Үүнийг бид бариад байгаа л даа.

Энэ дээр харин та нар ажлын хэсгийнхэн хариулаарай.

Хууль гэдэг дотор Үндсэн хууль гэж ерөөсөө заагаагүй байгаа шүү. Энэ Үндсэн хуулийг ярьж байгаа шүү дээ. Бид. Үндсэн хууль батлах гэж заагаагүй. Хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах гэж заасан байгаа шүү.

Тэгэхээр нийт ард түмний санал асуулгаар үүнийг шийдмээр байна. Тэд нар маань харин 300 болгемоор байна, 500 болгемоор байна гэвэл би дуутгүй байна.

Ингээд би та нараас юу асуугаад байна вэ гэвэл яг энэ дагах журмын тухай хуулийн асуудалтай холбогдуулж юм яриагүй. Үнэн. Би хуулиа барьж байгаа шүү. Яг энэ асуудалтай холбогдуулж юм яриагүй.

Энэ асуудлыг шийдэх механизмтай, арга замтай нь холбогдуулж би асууж байна. Үүнийг ард түмэн эсэргүүцээд байхад хоёр, гуравдугаар хэлэлцүүлэг гээд 76 бид чуулган дотор орж ирж хаалгаа хааж байгаад дөрөвний гурваар шийдчих нь арай л дэндүү.

Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй саналаар батлах нь ард нийтийн хүсэл бодол дээгүүр алхсан жудаггүй үйлдэл болж байна гэж би үзэж байна. Энэ байр сууриа би Улсын Их Хурлын дарга, Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Нийгмийн

бодлогын байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд энэ саналуудаа, би саналаа гаргана.

Өнөөдөр би санал хүргүүлж байна. Ингээд миний асуух асуулт бол энэ хоёрдугаар хэлэлцүүлгээс хойш ард нийтийн санал асуулгаар энэ асуудлыг шийдэх боломж байгаа гэдэгт би итгэлтэй байж болох уу?

**П.Анужин:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асуулаа.

Асуултад Хууль зүй, дотоод хэргийн яам 1 номер хариулах уу? Сайдыг дуудаарай. 2 номерын микрофонд Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар хариулна.

**Ж.Эрхэмбаатар:** С.Ганбаатар гишүүний асуултад ажлын хэсгээс хариулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийг Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан байгаа.

Энэ өргөн барьсан төслийг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцээд явж байгаа.

С.Ганбаатар гишүүний асуусан ард түмний нийтийн санал асуулгаар оруулах эсэх асуудлыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлээр маш нарийн зохицуулсан байгаа.

Энэ 17 дугаар зүйлээр Улсын Их Хурал хэрвээ Үндсэн хуульд оруулах өөрчлөлт нь ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд Улсын Их Хурлын нийт гишүүдийн



гуравны хоёроос доошгүй саналаар дэмжигдээд явбал энэ журмаар батлах асуудал хууль зүйн хувьд нээлттэй байгаа.

**П.Анужин:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн микрофонд. Та нэмэлт тодруулах зүйлээ микрофонд хэлээд.

**С.Ганбаатар:** Баярлалаа.

Тэгэхээр би ард нийтийн санал асуулгаар явах ёстой гээд энэ журмын тухай хууль дээр байна л даа. Бодитой ил тод байх. 5.1.3-ыг хэлж байгаа юм шүү.

Ер нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатад дараах үндсэн зарчмыг баримтална гэж байгаа юм.

Тэгэхээр 5.1.1 Үндсэн хуулийн дээдлэх, сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах. 5.1.2 ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах. Бүрэн эрхт байдал, оролцоог хангах гэж байгаа. 5.1.3 бодитой ил тод байх.

Тэгэхээр энэ 5.1.3-ын замаар иргэдийн санаа бодлыг судалж, харгалзах гэдэг утгаар өнөөдөр би зарчмын зөрүүтэй санал гаргаад Улсын Их Хурлаар ард нийтийн санал асуулгаар явуулъя гэдэг зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаагаа би илэрхийлж байна. Үүнийг Улсын Их Хуралд танилцуулж оруулна гэж би итгэж болох уу? Цаасан дээр бичих ёстой юу? Техникийн хувьд яах ёстой вэ?

**П.Анужин:** С.Ганбаатар гишүүн ээ, таны асуултад Байнгын хороо хариулъя.

Та хэрвээ зарчмын зөрүүтэй санал гаргах бол зөвхөн өргөн барьсан хуулийн

төслийн зүйл, заалттай холбоотойгоор зарчмын зөрүүтэй санал гаргана.

Саяын таны хэлсэн ард нийтийн саналыг бид Байнгын хорооныхоо санал, дүгнэлтэд тусгаад Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ. Зарчим ийм байгаа.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуусан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд Хишгээгийн Нямбаатар хариулна.

**Х.Нямбаатар:** С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хоёр үндсэн аргыг Монгол Улсын Үндсэн хуульд хуульчилсан.

Энэ нь нэгдүгээрт Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүд болон хууль санаачлах эрх бүхий бусад субъектүүдээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд заасан хүрээ хязгаарын дотор Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, хуулийн төслөө өргөн бариад Улсын Их Хурлын нийт гишүүдийн 57-гоос дээших нь дэмжиж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах процессыг Үндсэн хуульд нэгдүгээр аргаар томьёолсон байгаа.

Хоёр дахь арга нь ард нийтийн санал асуулга явуулах. Ийм хоёр дахь үндсэн арга байдаг. Энэ тохиолдолд Улсын Их Хурлын нэр бүхий. Би андуураагүй бол 25-аас доошгүй гишүүн ард нийтийн санал асуулга явуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг.../минут дуусав/

**П.Анужин:** Х.Нямбаатар гишүүнд нэмэлт минут өгье. Хариултаа гүйцээгээд хариулъя.

**Х.Нямбаатар:** Саяын хэлсэнчлэн Их Хурлын тийм тооны гишүүд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлаад уг асуудлаар Улсын Их Хурал уг тогтоолын төслийг баталсан тохиолдолд ард нийтийн санал асуулга явах процесс эхэлнэ.

Ард нийтийн санал асуулга явуулах процесс эхлээд сонгуулийн журмаар ард нийтийн санал асуулгыг зохион байгуулаад санал асуулгын дүн гарсан тохиолдолд түүнийг Улсын Их Хурал ёсчлон батлах гэсэн ийм хоёр үндсэн аргатай.

Тэгэхээр өнөөдрийн бид нарын өргөн бариад байгаа төслийн тухайд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эхний нэг дэх арга буюу хууль санаачлах эрх бүхий субъектүүд энэ төслийг өргөн барьсан энэ аргаар явж байгаа учраас яг энэ хоёр зөрчилдөөнтэй байдлын үед зарчмын зөрүүтэй саналаар Байнгын хороон дээр санал хураах ийм боломжгүй гэж ойлгож болно.

Хоёрдугаарт, би нэг зүйлийг дахин дахин. Өмнө нь би сая Хууль зүйн байнгын хороон дээр ч сануулж хэллээ.

2022 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01, 02 дугаар дүгнэлт гарсан. Энэ цэцийн 01, 02 дугаар дүгнэлт гарахдаа Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг анх удаа ашигласан байдлаар гарсан.

Тэр нь юу вэ гэхээр цэц Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг

хууль санаачлах эрх бүхий субъектүүдээр уламжилж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдүүлэх энэ арга замаар 01, 02 тоот дүгнэлтүүд гарсан.

Үүний дагуу та бид бүгд хамтдаа Улсын Их Хурлын 2022 оны 54 дүгээр тогтоолоор Засгийн газарт дээр ирсэн саналтай холбогдуулан Үндсэн хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл санаачлахыг Засгийн газарт даалгасан.

Энэ дагуу Засгийн газар өнөөдрийн энэ төслийг өргөн барьж байгаа гэдгийг бас нэмж хэлье.

**П.Анужин:** Баярлалаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурал ард түмний төлөөллийн байгууллага.

Тэгээд энэ төлөөллийн байгууллага ард түмний төлөөллийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна гэж үзээд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг тоо тогтолцоотой холбоотойгоор өөрчлөх шаардлага гарсан гээд бид үзэж байгаа шүү дээ. Тийм ээ.

Мэдээж 4 үндэслэл ярьж байна. Нэгд нь, хууль эрх зүйн хувьд, нийгэм, улс төрийн хувьд, эдийн засгийн хувьд, геополитикийн хувьд гэсэн энэ үндэслэлүүд нь өөрөө парламентын чадавхыг дээшлүүлэх. Давжаа парламент биш. Парламент нь иргэдийнхээ хүн ам, газар зүй, энэ нөхцөл байдалтай уялдаж бас чадамжтай байх ёстой гэдэг үүднээс асуудлыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирж байгаа гэж бид ойлгож байгаа.

Сая ард түмэнтэйгээ уулзахад 120 дотор бол болно. 152-ыг бараг 80 гаруй хувь нь дэмжихгүй байсан шүү дээ.

Ингээд хоёр намын бүлэг ярилцаад, гишүүд ч нэлээд өөрсдийнхөө тойрог дээр ажилласан зүйлтэйгээ уялдуулж асуудлыг хөндөөд 152 боллоо.

Ард иргэд ч дэмжихгүй байна. Больё гээд Улсын Их Хуралд суудалтай 3 нам нийлээд 126 болгоод оруулж ирж байгаа юм байна л даа.

152 байснаа 126 болголоо гэж байна. Тэгээд ямар үндэслэлээр жишээлбэл 126 гэдэг тоог оруулж ирж байгаа юм?

Өмнө нь куб язгуураар бодоод 152-оор зайлшгүй гээд л ярьсан. Одоо 126 гэхээр 76 тойргоо хадгалаад дээр нь 50 болоод л 126 болгочихъё гээд байгаа юм уу?

Үүнийг жишээ нь 123 юм уу, эсвэл 108, 118 болгож жишээ нь яагаад болоогүй юм. Тийм ээ. Энэ 126 гэдэг тоог ямар үндэслэлээр яаж гаргаж ирж байгаа гэдгийг нэгдүгээрт тайлбарлаж өгөхийг хүсэж байна.

Хоёрдугаар зүйл нь, одоо яг энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах парламентын илүү ард түмний төлөөллийн байгуулгаа хүчтэй болгох шаардлага тулгарсны нэг үндэслэл нь нийгэм, эдийн засгийн байдал гэж байгаа.

Өнөөдөр соёлын салбарынхан үнэхээр гэвчихээ байгаад бүгд жагсаж байна л даа. Би бас дэмжиж байгаа. Яагаад гэвэл тэр хүмүүс өдөр шөнөгүй, бараг 24 цаг ажилладаг хүмүүс. Ар гэрээ орхиод хөдөө гадаа явдаг. Сургууль, эмнэлэг гээд сая тойрог дээр ажиллахад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт биш бүх иргэд орлоготойгоо холбоотой, хармаатай холбоотой асуудлыг нэгдүгээрт хөндөж тавьж байсан л даа.

Тэгээд энэ одоо үүнтэйгээ уялдах болов уу гэж би бодоод.

Өнөөдөр жишээ нь Засгийн газрын хуралдаанаар цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, инфляцтай уялдуулж нэмэх тухай асуудал хөндөгдсөн болов уу?

Одоо тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд оролцох ёстой. Энэ салбарын сайд энэ тухайгаа бас ярих ёстой.

Тийм учраас би салбарын сайдыг дуудах ёстой болов уу гэж бодож байна. Мэдээж үүнийг би Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэйгөө уялдаж асууж байгаа шүү. Тэгэхгүй бол бусад асуудалдаа хэлэлцэхгүй гэдэг. Энэ бол зайлшгүй асуудал.

Ер нь тэгээд л ийм асуудлуудаа шийдэхийн тулд л бид Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахаар ярьж байгаа гэдгийг аль аль нам нь, тэр тусмаа эрх барьж байгаа манай намын хувьд ярьж байгаа. Тийм ээ. Тэгээд энд эхлээд хариулт авъя гэж бодож байна.

**П.Анужин:** Х.Булгантуяа гишүүн албан ёсоор Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүн болсон байгаа. Х.Булгантуяа гишүүнийг дуудах нь зөв.

Үнэндээ ард түмэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өөрсдийнхөө өдөр тутмын амь амьжиргаа, цалин, тэтгэмжтэй холбож ярьж байсан ийм кэйс өөрөө нийтлэг учраас Нийгэм хамгааллын сайдыг хуралдаанд оруулж ирэхийг ажлын хэсгийнхэн холбоо бариадхаарай.

Ингээд Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний асуултад Хууль зүй, дотоод

хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би эхний асуултад хариулъя.

54 дүгээр тогтоолын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах шүү. Хэдүүлээ өнөөдрөөс эхлээд энэ “**нэмэлт, өөрчлөлт**” гэж ярихгүй. Зөвхөн “**нэмэлт**” оруулах төслийг боловсруулах ажлын хэсэгт эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй тодорхой хугацаанд ажилласан.

Ажиллаад хамгийн нэгдүгээрт бид барьж судалсан судалгааны материал юу вэ гэхээр 1992 оны шинэ Үндсэн хуулийг боловсруулахад тухайн үед төслийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн тоог анх хууль санаачлагч төсөл санаачлагчид хэдээр оруулж ирж байсан бэ гэдгээс эхэлж судалж эхэлсэн.

Сүүлд Монгол Улсын Ерөнхий сайд “**Үндсэн хуулийн эх сурвалж**” гэдэг томоохон архивын судалгааны материалыг эмхэтгэж хэвлүүлж Их Хурлын гишүүд болон бусад судлаачид, эрдэмтдэд тараасан.

Уг эх сурвалжийн хүрээнд үзэхэд анх төсөл дээр Улсын Их Хурлын гишүүдийн тоог 102 гэдэг тоогоор төсөл санаачлагчид өргөн барьж, хэлэлцүүлгийн шатад тухайн үеийн Ардын Их Хурлын депутатууд ер нь энэ хэт олон байна.

Тэр үед мэдээж хэрэг нийгэм солигдож байсан. Хуучин намын нөгөө төр барих тогтолцоо харьцангуй өөр байсан. Улс төрийн товчооны 12 гишүүн үндсэндээ шийдвэр гаргадаг байсан. Үүнтэй уялдаад хэд хэдэн санал хэлсэн гишүүд ер нь “зуун ямаанд жаран ухна” байна. Ер нь энэ 102-ыг 50 хувь багасгая.

Ингээд 51 гишүүний төлөөлөлтэйгөөр Их Хурлыг бүрдүүлье гэдэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргаад. Нөгөө талаас зөвшилцлийн ажлын хэсэг ажиллаад тэгээд 51, 102 хоёрын дундах тоо буюу 76 гэдэг тоог олж өнөөдрийн 76 гэдэг энэ тоо гарч ирсэн ийм баримттай юм билээ.

Мөн 1992 онд хэвлэгдсэн Үндэсний дэвшлийн намаас хийлгэсэн “**Парламентын ардчилал**” гэдэг судалгааны материалыг миний бие Их Хурлын архиваас, номын сангаас олоод гишүүн нэг бүрт хэвлүүлж тараасан. Та хэдийн туслахууд авсан байгаа. Тийм.

Тэнд та хэд сүүлээсээ хэд дэх хуудсыг анзаарч үзвэл манай улстай хүн ам ойролцоо улсуудын жагсаалт төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх зарчмуудыг харгалзахдаа зүгээр одоо эргээд жоохон шүүмжлэлтэй хандахад сонгодог ардчилсан парламенттай улсууд, зөвлөх үйлчилгээтэй парламенттай улсуудыг адилтгаж нэг түвшинд бичээд хүн амын дунджаар 1-ээс 2 сая хүн амтай улсад ер нь энэ тооны парламентын гишүүд байх юм болов уу гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн юм билээ. Энэ нь 1991 онд яг хэлэлцүүлгийн шатад гарсан судалгааны материал.

Зөвлөх үйлчилгээтэй парламент гэдэг бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэггүй. Зөвхөн хаан болон тэр угсаа залгамжилж байгаа шийдвэр гаргагчдад зөвлөгөө өгөх үйлчилгээтэй ийм парламентын тоотой нэлээд дүйж гарсан гэдэг ийм дүгнэлтэд бид сүүлд хүрсэн.

Ингээд куба язгуурын арга буюу 152 гэдэг энэ тоо бол манай математикийн эрдэмтэд бас энэ судалгааг гаргаж ирсэн. Бусад ер нь 5 сая хүртэлх хүн амтай улсуудад парламентын

гишүүдийн төлөөлөл ямар байна вэ гэдгийг гаргаж ирсэн.

Ингэхдээ 100 хувь пропорциональ тогтолцоотой орнуудад нэг өөр, холимог тогтолцоотой орнуудад хүн амын тоотойгоо харьцуулсан харьцаа нь өөр гэдэг ийм дүгнэлтэд хүрээд бид ер нь энэ куба язгуураар 152 гэж өргөн барих нь ер нь зөв юм гэдэг дүгнэлтэд хүрсэн.

Ингээд 50, 50 гэдэг харьцаа яаж гаргаж ирсэн бэ гэхээр нэгдүгээрт Монгол Улс газар нутгийн хувьд өргөн уудам нутаг дэвсгэртэй.

Тийм учраас газар нутгийн төлөөллийн зарчим гарцаа байхгүй байх ёстой юм байна. Үүн дээр сүүлийн бид нарын 30 гаруй жилийн алдаа оноо юунд оршсон бэ гэвэл макро эдийн засгаа тэлэх тал дээр, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлэх тал дээр бид дэвшил гаргажээ.

Гэхдээ илүү чамлалттай байна. Тухайлах юм бол 1990 онд дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох орлого ойролцоогоор 338 ам.доллар байсан бол сая 2023 оны 01 сарын 01-ний статистикаар нэг хүнд ногдох орлого 5033 ам.долларт хүрч 17 дахин өсжээ. Гэтэл үүнтэйгээ харьцуулсан харьцаагаар 1990 онд ядуурлын түвшин 34 хувьтай байсан. Гэтэл өнөөдөр 28 хувьтай байгаа нь ердөө 6-хан хувиар. Эдийн засаг нь 17 дахин тэлсэн хэрнээ ядуурал 6-хан хувиар буурсан нь энэ макро эдийн засгийг тэлэх, хүний хөгжлийн тэр чанарыг нэмэгдүүлэх тал дээр бид бас энэ 33 жилийн хугацаанд алдаатай бодлогууд явуулжээ.

Эдийн засаг тэлэхэд бид нарт хамгийн их том чөдөр тушаа болсон юм бол эрчим хүчний салбарт байна. Тухайлах юм бол.

1984 оноос хойш нэг ч том эрчим хүчний төсөл хэрэгжүүлээгүй нь бид нарын эдийн засгаа тэлэхэд гол гаргасан алдаа байна. Жижиг төсвөө зөвхөн тойргийн зарчмаар хуваарилдаг энэ тогтолцоогоор явсантай холбоотой байна.

Ийм учраас том төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, макро эдийн засгийг өөд татах бодлого хэрэгжүүлдэг салбар салбарын эрдэмтэд, бүлэг, бүлгийн төлөөллүүдтэй, ийм газар нутгийн төлөөллүүдтэй зарчим байх ёстой юм байна гэдэг агуулгаар оруулж ирсэн.

Яагаад 40, 10 гээд 126 гэдэг тоон дээр ирсэн бэ гэхээр Үндсэн хууль өөрөө зөвшилцлийн баримт бичиг. Консенсус дунд батлагдах ёстой.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гол гол шийдвэрүүд, заавал хэрэгжих шинжтэй шийдвэрүүд дандаа 100 хувийн консенсус дунд гардаг.

Тэр утгаараа өнөөдөр парламентад суудалтай улс төрийн хүчин Ардчилсан намаас ер нь тоог бууруулья, 40, 60-ын харьцаатай болгоё гэдэг ийм санал орж ирээд. Тийм. Доторх тогтолцоон дээрээ.

Тэгээд одоогийн 126 гэдэг 39.5 хувь, 59.5 хувьтай ийм пропорц байгаа байх. Манайхан дахиад бодоод гаргачхаарай. Өөрөөр хэлбэл Ардчилсан намын гаргасан 40, 60-ын харьцаатай гэдэгтэй дүйж очиж байгаа зүйл байгаа.

Хоёрдугаарт, Ерөнхий сайд, Засгийн газраас барьж байгаа хатуу нэг бодлого одоогийн 76 гэдэг энэ орон нутгийн төлөөллийн зарчмыг ерөөсөө хөндөхгүй байя. Өөрөөр хэлбэл энэ нь нэлээн тогтоод ирчихсэн одоогийн парламентын болон өмнөх үе үеийн

гишүүд тойргийнхоо зовлон жаргалыг дэндүү сайн мэддэг энэ тогтолцоог эвдэхгүй байя гэж байгаа юм.

Энэ нь бас нэг талдаа учиртай юм билээ. Жишээлэхэд, Австралид газар нутгийн төлөөлөл. Нөгөө абориген буюу уугуул үндэстнүүдийн төлөөллийг хүртэл хатуу цаг ямагт хадгалж ирсэн ийм сонгуулийн тогтолцоо бас байдаг. Энэ зарчмыг бид энэ төслийг боловсруулах үедээ хэд хэдэн юунууд дээр харсан.

Тэгэхээр энэ зарчим дээрээ явъя. 76 нутаг дэвсгэрийн төлөөлөл. Нэмэх нь шинээр пропорциональ элементийг оруулж ирэхдээ 39, 40 хувиас дутуугүй түвшинд бодлого орж ирээд.

Энэ дотор боловсролын салбарын төлөөлөл, эрүүл мэндийн салбарын төлөөлөл, гадаадад сууж байгаа монголчуудын төлөөлөл, цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл гээд бүлгүүдийн төлөөллийг оруулж ирэхэд ч гэсэн 50-иас доошгүй тооны лист үүсэх шаардлагууд байна гэж үзээд зөвшилцлийн асуудал яригдаж байгаа.

Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцүүлэг дээр зөвшилцлийн тоог санал хураах асуудал яригдахгүй байх. Маргааш Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ асуудал.../минут дуусав/

**П.Анужин:** Х.Нямбаатар сайд асуултад гүйцээгээд хариулья.

Дараа нь М.Оюунчимэг гишүүн. Эхлээд тодруулчихъя гэж үү? Тэгье. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууна.

**М.Оюунчимэг:** Х.Нямбаатар сайд эдийн засгийн үндэслэл, тэгээд хүн амын

бодлоготой уяж л ярьж байна л даа. Үүнийг л бид бас яриад байгаа.

Гэхдээ бид парламентынх гэдэг чинь ард түмний төлөөллийн байгууллага. Нийгмийн бүх салбарын төлөөллийг энд оруулах нь өөрөө чухал байгаа гэж байна л даа.

Тэгэхээр өнөөдөр бүр зохион байгуулалттайгаар жишээ нь энэ парламентын засаглалаа нэг талаасаа чадамжлуулахаа ярингуутаа нөгөө талаасаа 76 хулгайч гэд юм уу, эсвэл 76 гээд энэ парламентын нэр төр, энэ үнэт зүйлийг нь унагах Пи Ар бодлого давхар яваад байна л даа. Үүнийг бид бас харж байна шүү дээ.

Тэгэхээр сая та төлөөлөл гэж байна. Тэгвэл 78, 48 гэж болохгүй юу? Заавал 50 жагсаалтад орох ёстой гээд.

Ер нь тэгээд иргэд жагсаалтад тийм ч дуртай биш байгаад байгаа шүү дээ. Яагаад гэвэл ард түмэн өөрөө өөрсдөө сонгодог байя гээд байгаа. Гэхдээ саяын таны хэлж байгаа том төслүүд явахгүй байна. Газрын тос, эрчим хүч, тэгээд л нийгмийн амьдрал, өнөөдрийн ядуурал 28 биш бүр 30 гарчихсан ч байгаа. Өнөөдөр инфляц бүр ч хэцүү байдалд ороод байна л даа. Энэ гадаад геополитикийн нөхцөл байдал ч нөлөөлж байна. Тийм ээ.

Тэгэхээр 76 гэдгийг бүр хатуу хадгална гэсэн бодол бүр хатуу байгаа юм уу, эсвэл 78, 48 болох хувилбар гэж харж байгаа юу?

**П.Анужин:** Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар гүйцээж хариулья.

**Х.Нямбаатар:** Би түрүүчийн М.Оюунчимэг гишүүний хоёр дахь асуулт дээр дутуу хариулсан байна.

Юу гэхээр М.Оюунчимэг гишүүн ээ, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэж байх үед өнөөдрийн нөхцөл байдал, гадаа болж байгаа соёлын салбарынхны жагсаал, цалин нэмэгдүүлэх шаардлагатай холбоотой Засгийн газар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байна гэдэг асуудал тавьсан.

Засгийн газар дээр ямар асуудал ярьж байгаа гэвэл ер нь энэ 6 дугаар сардаа багтаад төсвийн тодотголоо хийе гэдэг нэг байр суурьтай байгаа.

Энд хэд хэдэн асуудал хөндье гэж байгаа юм. Энэ удаагийн төсвийн тодотголыг цалин, тэтгэвэр нэмэгдүүлэх гэж нэрлэмээргүй байна гэж байгаа юм. Яагаад гэвэл бид цалин, тэтгэврийн ялгамжтай байдлыг арилгах төсвийн тодотголыг хийх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл хууль сахиулах салбар энэ тэрд цалингийн доод хэмжээ үндсэндээ нэг сая төгрөг хүрчхээд байгаа.

Тэгэхээр хамгийн их хоцрогдоод байгаа салбар бол үндсэндээ жишээлбэл соёлын салбар байгаа.

Тэгэхээр соёлын салбарын хамгийн доод цалингийн итгэлцүүрийг.../минут дуусав/

**П.Анужин:** Энэ маш чухал. Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой ард иргэдээс гарсан нийтлэг санал учраас Хишгээгийн Нямбаатар гишүүнд гүйцээж хариулах нэг минутыг өгье.

**Х.Нямбаатар:** Тэгэхээр энэ бол эхлээд ялгамжаа арилгачихья. Хамгийн

доод цалинтай хүмүүсийг бусад салбаруудын доод түвшинд аваачья.

Ингээд цалингийн зуун хэдэн өөр ялгамжтай байдлыг маш цөөхөн ялгамжтай байдал руу аваачиж байгаад, ялгаатай цалингийн тогтолцоо руу аваачиж байгаад дараа нь ирэх оноос эхлээд Ерөнхий сайд олон нийтэд зарласан тухайн жилийн инфляцын түвшинтэй уялдуулж цалин хөлс, худалдан авах чадварыг алдагдуулахгүй байдлаар нэмэгдүүлье гэдэг нэг зүйл ярьж байгаа.

Хоёрт нь, Монгол Улсын үнэт Үндсэн хуульд заасан Хоёрдугаар бүлгийн тэр хүний эрхтэй холбоотой “хүн бүр хууль, шүүхийн өмнө адил тэгш байх энэ зарчим бас хүүхдийн мөнгөн дээр алдагдаад байна.

Өнөөдөр 90 хувь нь статистикийн байгууллагын дүн мэдээгээр авдаг. Статистикийн дүн мэдээгээр 10 хувь нь авахгүй байгаа нь бас зарим талдаа хүүхдүүдийг хохироож байгаа асуудал байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн. Энэ бол халамжийн бодлого биш юм. Хүн ам цөөтэй Монгол Улсын хувьд хүн ам зүйн.../минут дуусав/

**П.Анужин:** Чухал хариултуудыг чухал асуултад өглөө.

Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

**Б.Бейсен:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр орон нутагт яваад ажиллаад ирлээ л дээ.

Гол нь ард иргэд энэ нэмэх асуудлыг эсэргүүцэж байна. Ерөөсөө. Тэгээд 152 болгох гэж байна та нар.

Тэрийг дагаад бас ажлын алба гээд 4-өөс 5 хүн нэмэгдэнэ. Тэгээд л та нар цалин, тэтгэвэр нэмэхгүй байж гээд тэгж байна.

Нөгөө талаар саяын нөхцөл байдал дээр чинь баруун аймгууд дээр чинь цас орсон. Зудын байдалтай. Хөдөлмөрчид ихээр оролцож чадахгүй байна. Ирэхгүй байна. Өвс 50 мянга хүрсэн. Хорголжин тэжээл 80 мянга хүрсэн. Та нар ингээд л зуд болж байхад зуд болж ирж байна гээд ерөөсөө тэгж байгаа юм чинь.

Тийм учраас энэ дээр сая тараах материал нь ч гэсэн уг нь аятайхан гарын авлага болсон байна. Гэтэл нөгөөдөх нь бас дутуу. 600 хүн цуглаж байхад тэгээд 150-ийг тараахад та нар бас энэ мөнгийг нь идчихсэн юм уу. Яагаад дутуу тараагаад байгаа юм гээд л загнах юм.

Тийм учраас 99 байвал ч 23 гишүүн нэмэгдэх юм байна. 108 байвал 32. 126 байвал 50. Тэгээд 152 байвал 76 нэмэгдэх юм байна л даа. Яг хэдээр яах гэж байна үүнийг яг. Тодорхой хувийг нь. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, гишүүдийн үүнийг батлаад явуулчихдаг. Цаана нь ажлын албан гээд хэчнээн хүн байх юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 8 жилийн хугацаанд Үндсэн хуульд хүрэхгүй гэсэн юутай байгаа шүү дээ. Гэтэл энэ хуулийн хүрээнд болж байна уу? Энэ талаар асууя.

**П.Анужин:** Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

**Х.Нямбаатар:** Би Б.Бейсен гишүүний асуултад товчхон хариулъя. Энэ миний цаг аягүй богино байна. Сүүлийнхээс нь хариулъя.

2022 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 01, 02 гэсэн дүгнэлтээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн 68.2 дахь хэсэгт заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ боломжийг анх удаа ашиглаж дүгнэлт гаргасан.

68.2 дээр ямар зохицуулалт байдаг вэ гэхээр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц хууль санаачлах эрх бүхий субъектэд уламжлах ийм зохицуулалт байгаа.

Энэ утгаараа Үндсэн хуулийн цэц 01, 02 дугаар дүгнэлтээр нэгдүгээрт энэ хүн амын өсөлттэй уялдуулж Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор тогтолцоог өөрчлөх ийм санал, дүгнэлтийг гаргасан.

Энэ дүгнэлтийг Их Хурал хүлээж аваад Улсын Их Хурал 34, 54 гэдэг хоёр тогтоолыг 2022 онд баталсан.

54 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газарт цэцээс ирсэн саналын дагуу хууль боловсруулах асуудлыг Улсын Их Хурал та бид бүгд Засгийн газарт үүрэгжүүлсэн.

Засгийн газар энэ саналын дагуу өнөөдрийн энэ Үндсэн хуулийн 21.2 дахь хэсэгт заасан нэмэлтийн төслийг боловсруулж одоо бид бүхэн ингээд хэлэлцээд явж байна.

Энэ тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн 68.2-ыг ашиглаж Улсын Их Хуралд ирүүлсэн тэр дүгнэлтийн хүрээнд энэ тоо тогтолцоог хөндөж байгаа асуудал нь 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуультай зөрчилдөөгүй гэж бид үзэж өргөн барьж байгаа гэдгийг хэлье.



Хоёрдугаарт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн гол агуулга бол нөгөө 8 жил уг асуудлыг хөндөхгүй байх гэдэг нэг цоож байгаа.

Дараагийн гурван цоож нь болохоор Их Хурал өөрийнхөө эрх хэмжээг нэмэгдүүлж болох төсөл өргөн барьж болохгүй, Засгийн газар өөрийнхөө эрх хэмжээг нэмэгдүүлэх төсөл өргөн барьж болохгүй, гурав дахь нь Ерөнхийлөгч өөрийнхөө эрх хэмжээг нэмэгдүүлэх төсөл өргөн барьж болохгүй гээд.

Тэгэхээр энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд байгаа хязгаарлалтыг тойрохын тулд Их Хурал 54 дүгээр тогтоолоороо Их Хурлын тоо, тогтолцоог өөрчлөх асуудлаар төсөл боловсруулж, санаачилж, өргөн барихыг Засгийн газарт даалгасан гэж би таныг гурав дахь асуултад хариулъя.

Хоёр дахь асуултад, та ер нь Их Хурлын гишүүдийн тоог нэмэх тал дээр Баян-Өлгийчүүд бүгд эсрэг байна гэж би ойлголоо. Таны хэлж байгаагаар. Тийм үү.

Тэгэхээр ер нь 76 Их Хурлын гишүүд өөр өөрсдийн тойрогт ажилласан. Энд өчигдөр бүлэг дээр ч гэсэн манайхан бүх ирсэн саналуудыг нэгтгэсэн. Дийлэнх санал юу гэсэн бэ гэхээр тоо нэмэгдүүлэхийг дэмжиж байна. 152 бол биш ээ. Үүнээс арай бага түвшинд Их Хурлын гишүүдийг нэмэгдүүлэх тал дээр та нар дахиж ярилцаад эргэж ирээрэй гэдэг үүрэг даалгаврыг өгсөн.

Тэгэхээр өнөөдөр танай намын удирдлагууд, манай намын удирдлагууд, ХҮН намын удирдлагууд, сая олон

нийтэд хэвлэл мэдээллийн байгууллагад мэдэгдэл хийж байна.

Тэгэхээр 1776 онд Америкийн Нэгдсэн Улсад анхны нийгмийн гэрээ байгуулагдаж байсан. Тэр гэрээнээс би заримыг нь зөрүүтэй хэлж байж магадгүй. Ишлэж хэлэхэд бид дараах эрхээ маргаангүй эдлэхийн тулд бид нэгдэж энэхүү нийгмийн гэрээнд, Тусгаар тогтнолын тунхагт гарын үсэг зурж байна гэдэг ийм үг, өгүүлбэр, ишлэл байдаг.

Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах асуудал ч гэсэн ялгаагүй бүх гишүүдийн зөвшилцөл дунд явахаас биш зарим нэг эсрэг санал хэлсэн, цөөнх болсон зүйл дээр үндэслээд нэмэлт оруулах энэ төслөөс шууд бид ухралт хийх нь нийгмийн гэрээнийхээ суурь зарчмаас ухралт хийж байгаа нэг ийм хэлбэр гэж би ойлгож байгаа.

Би түрүүн М.Оюунчимэг гишүүний асуултад дутуу хариулсан зүйл нь бид 30 жилийнхээ алдаа оноонд дүгнэлт хийж Монгол Улсын Засгийн газар **“Шинэ сэргэлтийн бодлого”** гэдэг бодлогын баримт бичиг гаргаж ирсэн.

Энд хамгийн гол асуудал бид эрчим хүч, аж үйлдвэрийн салбартаа бид үнэхээр ухралт хийжээ. 30 жилийн хугацаанд. Яагаад гэвэл том бодлого явуулдаг, том шийдвэрүүд энэ хугацаанд төдийлөн гарсангүй.

Эрчим хүчний тавдугаар эх үүсвэрийг барина гээд одоо миний мэдэхээр 20 жил болж байна. 4 газар тууз хайчилсан. Гэтэл хөгжиж байгаа улс орнууд эдийн засгийнхаа өсөлтөөс нэг дахин давсан эрчим хүчний үйлдвэрлэлийг өмнөх жилүүдэд нь үйлдвэрлэж явж байж тухайн орны аж үйлдвэрийн, эрчим хүчний бүх өсөлтүүд хангагдаж явдаг.

Гэтэл бид 1984 оноос хойш нэг ч эрчим хүчний эх үүсвэр, нэг ч турбин нэмэлгүйгээр өнөөдөртөө золгож байгаагийн гороо өнөөдөр амсч байгаа. Бид хойд талдаа Оросын Холбооны Улсаас 30 хувийн эрчим хүчээ авч байна. Зүүн талдаа авч байна. Урд талдаа авч байна. Танай нутаг ч авч байна.

Тэгэхээр бид энэ чиглэл рүү төрийн бодлогыг. Нөгөө талдаа газар нутаг, тойрог, орон нутгийн хөгжлийг хамтатгасан, хүний хөгжлийг бодсон ийм төрийн бодлого, шийдвэрийг гаргаж ирэх.

Бусад хөгжсөн улс орнуудын жишгээр пропорциональ, мажоритар тогтолцооны хосолсон хэлбэрээр улс орнууд эдийн засгийнхаа өсөлтийг хангажээ.

Ийм учраас хөгжсөн орнуудын туршлагаар энэ тогтолцоог оруулж ирье гэдэг л ийм зүйлийг ажлын хэсэг, судлаачдын түвшинд ярьсан гэдгийг би танд нэмж хэлье.

**П.Анужин:** Баярлалаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Бусад гишүүдийн адил тойрогтоо очиж Үндсэн хуулийн нэмэлттэй холбоотой асуудлыг танилцуулж, санал бодлыг нь сонсож ирсэн.

Манай Хэнтий аймгийн сонгогчид айхтар нэг их сандал, суудал ярихаар ирлээ гэж хүлээж аваагүй.

Мэдээж амьдрал дээр байгаа хүнд хэцүү, тэр үнийн өсөлт, янз янзын

асуудлуудыг бид чуулганы завсарлагаанаар маш их очиж уулзаж, ярьж, мөн зүгээр сонсоод өнгөрөх биш энэ чуулганы танхим дээр ирж тэр нөхцөл байдлыг Байнгын хороо, бүлгийн хурал, Улсын Их Хурал дээр байнга хэлж ярьж ингэж ажилласан.

Харин тухайн үед гаргасан тэр саналуудын үйл явц яг өнөөдөр ямар байгаа юм, тэтгэвэртэй холбоотой тэр нийгмийн даатгалын багц хууль ямар байгаа юм, цалин хөлсний тэр зөрүүтэй байдлыг яах юм, үнийн өсөлтийг яах юм гэдэг энэ танилцуулгуудаа хийгээд ирсэн.

Яах вэ зүгээр улс орны парламентууд шийдвэр гаргахдаа магадгүй тухайн үед ард иргэдийн хувьд дэмжихгүй, таалагдахгүй, тийм шийдвэрүүд гаргах түүхэн цаг үе ч бас ирдэг л байх.

Гэхдээ энэ болгоны өмнө бид иргэдэд таалагдана гэхээсээ илүүтэйгээр улс орны цаашдын хувь заяа, бас бодож шийдвэр гаргадаг ийм субъект учраас Үндсэн хуулийн энэ өөрчлөлттэй холбоотой асуудал дээр ард иргэдтэйгээ маш илэн далангүй, ний нуугүй, нэг их гоёчилж биш ингэж л ярьж уулзалтуудыг хийсэн.

Тэгээд бидэнд байгаа ард иргэдээс ярьж байгаа энэ зүйлүүд мэдээж гадаад хүчин зүйлийг бид нэлээн сайн тооцож үзэх ёстой юм билээ шүү дээ. Яг дотроо л 76 сайн муу, энэ тэр, 76 дээр хэдийг нэмчих юм бол төсөв болохоо байлаа гэж яриад байгаа боловчиг бидний явж ирсэн, бидний хүүхэд байхаас явж ирсэн энэ дэлхий чинь шал өөр болж байгаа гэдгийг гадна дотнын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Монголын ард түмэн харж байгаа, ойлгож байгаа юм билээ.

Дотоод хүчин зүйл гээд ярих юм бол 30 жил явж ирсэн өнөөдрийн Монголын ард түмнийг ийм байдалд оруулсан энэ тогтолцоог л бас нэг гэрэлтэй гэгээтэй юм нэмэх гээд байна. Энэ алдаагаа засах гээд байна гэсэн ийм том агуулга явж байгаа л гэж би харж, тэгж л танилцуулж явсан.

Үнэхээр бидний өнөөдрийн байгаа байдал бас тийм сайнгүй байгаа гэдэг нь үнэн шүү дээ. Энэ авлигатай тэмцэх ажил 30 жил зүгээр л лоозон маягаар явж ирсэн бол одоо харин нэлээн хүчтэй сөхөж гаргаж ирж. Тэгээд л танай манайг энэ асуудалд орооцолдож, одоо л нэг юм цэгцрээд л. Цэгцлээд л жил гаран хэртэй болоход л улсын төсөв чинь бараг 600, 700 тэрбум төгрөгөөр давж байна шүү дээ. Анх удаа юм билээ шүү дээ.

Тэгэхээр цаашдаа бид 30 жил явж ирэхдээ энэ алдаагаа засъя гэсэн ийм л том агуулгыг би нутгийн сонгогч олондоо нэлээн сайн дэлгэрэнгүй ярьж ирсэн гэдгийг хэлье.

Энэ дээр тогтолцоон дээр иргэд сайн ойлгож байна. Үнэхээр Монгол Улсын төсвийг 76 гишүүнээр дамжуулаад 21 аймаг, 9 дүүрэг, цаашлаад 330 сум, бүр цаашлах юм 1600 баг руу хуваачихдаг. Том юм байдаггүй.

Улс орны хэмжээнд эрүүл мэндийн салбар болохоо байлаа гээд байхад сонгогдсон гишүүн нь тухайн сумын Эрүүл мэндийн төвийн цонхны шил яриад байхаас биш тэр салбарын том асуудал руу ордоггүй. Тэгээд энэ нь гал унтраах маягаар явсаар байгаад л бүх салбарууд дээр ийм хүндрэлүүд үүсээд л өнөөдөр ийм байдалтай л болчихсон юм. Үүнийгээ засъя гээд.

Тэгэхээр иргэд тогтолцоон дээр дэмжиж байна. Тэр орон нутгийн

төлөөлөл байх уу гэдгийг зайлшгүй байх ёстой. Энэ олон сумд очиж ажилладаг байх ёстой. Тэгэхгүй бол дан нөгөө пропорционалиар ороод ирэх юм бол суманд очно гэхээсээ илүү Үндэсний телевиз дээр очоод л очерлоод зогсчих юм билээ шүү дээ. Нэвтрүүлэгт орьё гээд л.

Тэр сумын амьдрал ямар байгааг хардаг харах, тэнд очиж мэдэрдэг байхын тулд энэ зөв гэж байгаа юм.

Тоон дээр мэдээж 152 гэдгийг 76 дээр нэмэх нь 76, 152 гээд ойлгочихсон юм шиг байгаа юм. Судлаачид үүнийг гаргаж ирсэн юм байна гэж харж байгаа.

Ер нь сүүлийн үед аливаа улс орны хэмжээний том асуудлыг бид зүгээр улс төрчид хүнд таалагдах тоо хэлэхээсээ илүүтэйгээр судлаачид юу гээд үзээд байгаа юм бэ гэдгийг бас л бодож явах ёстой ийм л тоо гэж харж байгаа.

Тэгэхээр ер нь хараад байхад ард иргэдийн дунд амьдрал хүнд байна. Үүний буруутнууд энэ 76. Энэ 76 өөрсдөө бүгд хулгай зэлгий, эсэн бусын юманд орооцолдсон байна гэж яриад байгаа.

Тэгэхээр миний хувьд өнгөрсөн 30 жилийн өмнөх явж ирсэн энэ 76-гийн үүх түүхийг би сайн мэдэхгүй.

Миний энэ парламентад орж ирээд ажилласан цагаас хойш ялангуяа улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн тэр улс орны боломжуудаас хулгай хийх бололцоонуудыг би 30 жил анх удаа хаасан гэж ойлгодог. Тэр нь Эрүүгийн хуулийн өөрчлөлт. ЖДҮ-ээс зээл авсан Их Хурлын гишүүн гуравхан жилийн ял аваад л тэрнийхээ 1.5 жилийг нэг аймгийн хориход очоод л худгийн манаач, эсвэл номын санч хийж байгаад л

жил гарны дараа л гараад ирж байгаа шүү дээ.

Одоо би ойлгохдоо 12-оос 20 жил болсон гэж ингэж ойлгож байгаа.

Тэгэхээр би яг энэ хуулийг батлагдахад Улсын Их Хурлын гишүүд ингэж хувийн ашиг сонирхол, янз янзын юмаараа давамгайл байдал олдог энэ процесс хэрвээ үргэлжлэх юм бол 12-оос 20 жил авна гэж ойлгох нь зөв биз. Үүнийгээ ард иргэдэд ойлгуулмаар байна гээд байгаа юм.

Тэгэхээр хулгайчийн тоо нэмж байгаа биш, харин энэ улс орны хөгжлийг ярья. Хэрвээ итгэл алдаад хулгай хийх юм бол өмнөх 76 шиг биш юмаа гэдэг.

Энэ Эрүүгийн хуулийн өөрчлөлт, одоо энэ яригдаад байгаа Ашиг сонирхлын хууль. Тэр тендерт оролцохгүй байх, ах дүү нар нь дарга хийхгүй, зээл, тусламж авахгүй гэсэн энэ юмнууд чинь ирээдүйн Их Хурлын гишүүд нэг хазгай гишгэх юм бол 15-аас 20 жилийн ял авах ийм л бололцоог бүрдүүлээд байгаа.

Тэгэхээр Хууль зүйн яам энэ дээр яг эн Эрүүгийн хуулийн өөрчлөлт Их Хурлын гишүүд дээр яаж тусах юм бэ гэдэг тал дээр нэлээн сайн хэлж ярихгүй бол нөгөө Их Хурлын гишүүн болохоороо л ердөө тэгээд л эг маггүй хулгай хийдэг юм шиг, тийм бололцоо гараад ирдэг юм шиг л юм харагдаад байгаа.

Тэгээд дараагийн нэг зүйл бол 76-гийн нэг байна гэдэг чинь олно шүү дээ л гэж яриад байгаа юм. Яс үнэндээ энэ дотор ороод ирээд харахад 76-гийн нэг биш эрх баригч намын нэг болчихдог юм билээ шүү дээ. Эрх баригч намын нэг.

Тэгэхээр тэр чинь 39, 40-ийн нэг болчхож байгаа байхгүй юу. Бараг. Үндсэндээ 39, 40-ийн нэг кноп гэдэг чинь Ерөнхий сайдыг огцруулах хэмжээний юм болоод ирдэг учраас нэг кнопки ач холбогдол маш өндөртэй. Тэгээд тэр нь өөрсдөө давуу байдал үүсэх ийм юмнууд яриад байдаг юм.

Тэгэхээр би дараагийн асуух гээд байгаа нэг зүйл ард иргэд гишүүдийнхээ тоог нэмчих юм бол хулгайчийн тоо нэмэгдлээ гэж яриад байдаг. Энэ дээр хууль эрх зүйн хувьд ямархуу хаалт тээгүүд шинээр бий болсон юм бэ гэдэг энэ талын юмыг Хууль зүйн яам маань сайн хэлж яриач ээ.

Дараагийнх нь, ард иргэдийн яриад байдаг бас нэг зүйл. Ер нь яах вэ, одоо ингээд л 76 байх хэрэгтэй. Тоо нэмэх муу гэдгийг би нөгөө талаасаа юу гэж харж байгаа вэ гэвэл энэ 76-гийн нэг байж кнопоо үнэд хүргэх гээд байгаа хүмүүсийн л санаархал байдаг юм болов уу гэж би яг хувь хүнийхээ хувьд хардаг юм.

Тэгэхээр өмнөх явж ирсэн гишүүдийн энэ эрх мэдэл, энэ юу ч хамаагүй аваачаад хуруу дүрээд авч болдог энэ эрх зүйн орчин шал өөр болсон гэдгийг бас ойлгуулаад.

Дараагийнх нь, Их Хурлын гишүүдийн дархан эрхийн асуудал гэж нэг том зүйл. Яг эрхтэй ч юм шиг, эрхгүй ч юм шиг.

Би дөчин хэдэн жил эрхгүй явж амьдарсан. Надад тэр дархан эрхийн хэрэгцээ байхгүй. Яг энэ дотроос хараад байхад дархан эрхтэй юм шиг хэрнээ өнөөдөр шүүгдэгчээр суугаад л шүүх хурал танхимд мэдүүлгээ өгөөд л сууж байгаа.

Хэрвээ одоо тэгээд дархан эрх байх юм бол яаж байх юм. Байхгүй яаж байхгүй байх юм. Үүнийхээ учрыг олохгүй бол ард иргэд Их Хурлын гишүүн гэхээрээ л тамтаггүй дархан эрхтэй хүн. Хэн ч дуудсан очдоггүй нэг тийм том толгойтой нөхдүүд байна гэж бас ойлгоод байх шиг байна лээ.

Тэгээд энэ хоёр дээр хэрвээ энэ тоо юмнууд ингээд өөрчлөгдөх юм бол одоо бас ямар хуулийн.../минут дуусав/

**П.Анужин:** Ц.Идэрбат гишүүний асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хариулна.

**Х.Нямбаатар:** Юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулж байгаа энэ төслийн хүрээнд Их Хурлын гишүүдийн тоо, тогтолцооны хувьд өөрчлөлт оруулах төсөл өргөн баригдаж байгаатай зэрэгцэж, урьтаж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, урьдчилан сэргийлэх тухай хуульд маш том суурь өөрчлөлт орж байгаа.

Тэр өөрчлөлтөөр юуг хэлж байгаа вэ гэвэл улс төрд нөлөө бүхий этгээдүүд, Их Хурлын гишүүд өөрийн хамаарал бүхий компаниараа нээлттэй тендерт ч орохыг хуулиар хориглож байгаа.

Хуучин нээлттэй тендерт орох эрх нь нээлттэй. Бусад харьцуулалтын болон бусад хязгаарлалттай тендерүүдэд хориглосон байсан бол энэ удаа ерөөсөө өөрийнх нь хамаарал бүхий. Тэр дундаа өөрөө нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэдгийг бид анх удаагаа Үнэт цаасны тухай хуулиас ишлэл авч 5 хувиас дээш хувьцаа эзэмшдэг компанид нь хүртэл элдэв төрлийн хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл, бодлогын зээлүүд, нээлттэй тендерүүдэд орохыг бүгдийг нь хориглолт хязгаарлалт тавьж байгаа.

Дээр нь өөрийнх нь хамаарал бүхий этгээдүүд, улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн хамаарал бүхий этгээдүүд нь удирдах албан тушаалд томилогдох, сонгогдох, цаашлаад төрийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлагаар ажиллахыг хүртэл хориглосон зохицуулалт орж ирж байгаа.

Дээр нь нэмээд өөрийнх нь төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдүүд тийм ээ, дагавар хүүхэд нь Төрийн сангийн зээлээр суралцах эрхэд нь хязгаарлалт тавьж байгаа.

Тэгэхээр энэ Нийтийн албаны тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор цаашид ялангуяа Их Хурлын гишүүнээр нэр дэвших гэж байгаа хүмүүс гэр бүл, ах дүү, төрөл төрөгсөд, бизнесийнхээ хамтрагчидтай эхлээд ярилцаж байж нэр дэвшихээс өөр аргагүй байдалд орж байгаа.

Өөрөөр хэлбэл тэр нэг хүн өөрийнхөө сонгох, сонгогдох эрхийг эдлэх явцад бусдынх нь бизнесийн эрх ашиг хөндөгдөх тохиолдол үүсэж болзошгүй.

Ийм учраас үүнийгээ урьдчилж сонгож байж улс төрийн зам, нийтийн албанд ажиллах уу, үгүй юү гэдгээс сонголт хийх л ийм зүйл үлдэж байгаа юм.

Хоёр нь, Ц.Идэрбат гишүүн маш их гярхай ажиглаж харсан байна.

Энэ юу вэ гэхээр 1993 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Монгол Улсын Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдаж байсан юм.

Өөрөөр хэлбэл 1986 оны Эрүүгийн хуулийг 1993 онд шинэчлэхдээ нэлээн том суурь өөрчлөлт хийсэн юм. Энэ үед одоо Та бүхэн бас эргээд үзвэл энэ Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж байх үеийн протоколыг сөхөж үзвэл авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлогыг чангатгая гэдэг асуудал тухайн үед яригдаад тэгээд олонхын дэмжлэг авч чадаагүй юм билээ.

Дараа нь 2002 онд мөн албан тушаалын гэмт хэргийн бүлэгт өөрчлөлт ороод үүнтэй холбоотой ялын бодлогыг чангатгах асуудал бас яригдаад яг одоогийнх шиг 20 жилийн ялтай байлгая гэдэг асуудал яригдаад шийдэгдээгүй юм билээ.

Тэгээд сая бид анх удаагаа энэ 2022 оны 12 дугаар сард 30 жил хэртэй яригдсан Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлогодоо Монголын төр огцом өөрчлөлт гаргаж 20 жилийн ялтай болгож байгаа юм.

Энэ бол хүнийг санаатай алах гэмт хэрэгт оногдуулдаг, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулдаг. Тийм ээ. Ийм ялын бодлоготой дүйцүүлж аваачиж 20 жилийн ялын бодлоготой болгосон.

Тэгэхээр цаашид энэ төсөлтэй уялдуулж Засгийн газар дээр Ерөнхий сайдаас өгч байгаа чиглэл юу вэ гэхээр үүнтэй холбоотой бүх л хуулиудад цаашид хэдүүлээ өөрчлөлт оруулъя. Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль, цаашлаад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиуд. Нөгөө төрийн бус байгууллагуудынхаа тухай хуулиуд гээд.

Өөрөөр хэлбэл социал хүрээнд оролцогчдын дүрмийг 30 жилийн хугацаанд хэдүүлээ эргэж хараад, улс төр эрхлэх сонирхолтой хүмүүс нь улс төр хийдэг, бизнес эрхлэх сонирхолтой хүмүүс нь бизнесээ хийдэг ийм шинэ тоглоомын дүрмээр шинэ 30 жилийг эхлүүлэе гэдэг энэ агуулга явж байгаа.

Зарим хүмүүс шүүмжлэлтэй хандаад байна лээ. Яагаад Засгийн газар зөвхөн тоо, тогтолцоо гээд ганцхан асуудлыг хөндөж оруулж ирээд байгаа юм бэ гээд.

Ерөнхий сайд юу гэж ажлын хэсэгт чиглэл өгсөн бэ гэхээр нэг нам олонхоороо засаглаж байгаа үед нийгмийн гэрээг маш олон талаас нь хөндөх нь дэмий.

Өөрөөр хэлбэл энэ нөгөө легитим шинж чанар алдагдана. Тоогоо, тогтолцоогоо өөрчлөөд олон намын төлөөлөлтэй, нийгмийн олон бүлгүүдийн төлөөлөлтэй, цаашид нийгмийн гэрээндээ өөрчлөлт оруулах уу, үгүй юү гэдгийг хэрэв Үндсэн хуульд нэмэлт батлагдсан тохиолдолд шинэ парламент ярих асуудал.

Одоо бид нарт энэ 1992 оны Үндсэн хууль дээр эргэж харах хэд хэдэн зүйлүүд байдаг. Бид тэр нөгөө Шарль Луи де Монтескьё /Charles Louis de Montesquieu/, Жан-Жак Руссо /Jean-Jacques Rousseau/ нарын гаргаж дэвшүүлсэн “Засаглал хуваах онол”-ыг хүртэл яг манай одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуульд төдийлөн сонгодог утгаар нь томъёолж чадаагүй алдаанууд бий.

Шүүх эрх мэдлийн бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлууд бий.

Хүний үндсэн эрхийг хамгаалахтай холбоотой асуудал дээр эргэж харах зүйлүүд бий.

Одоо би хуульчийн хувьд, судлаачийн хувьд ярихад Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн шүүх байх юм уу, эсхүл шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүн нэг хэсэг байх юм уу гэдгээ бид эргэж харах, дахиж апдэйт хийх энэ тэр олон асуудлууд бий.

Гэхдээ үүнийг энэ удаад хөндөх нь нөгөө легитим тэр үүсэхгүй гэдэг агуулгаар бид зөвхөн тоотой, тогтолцоотой холбоотой асуудлыг ярьж байгаа юм.

Сая Б.Бейсен гишүүн ч хэлж байна, Ц.Идэрбат гишүүн ч хэлж байна. Хөдөөгүүр малчдын амьдрал хүнд байна. Энэ ган гачиг, зуд турхан их болж байна гээд.

Б.Бейсен гишүүн социализмын үед бас л хариуцлагатай ажил хашиж байсан хүн. Социализмын үед бид нарыг хүүхэд байхад өнөөдрийнх шиг ийм бэлчээрийн мал аж ахуй байгаагүй. Өнөөдрийн бэлчээрийн мал аж ахуйг би зохицуулалтгүй бэлчээрийн аж ахуй гэж хэлэх гээд байгаа юм.

Хуучин социализмын үед, нэгдлийн үед 4 хонинд, 5 хонинд нэг ямаа ноогдуулж сүргийн бүтцийг хангадаг, цөлжилт үүсэхээс сэргийлдэг. 4-өөс 5 сумын дунд сангийн аж ахуй байгуулж нэмэлт тэжээл, хүчит тэжээл өгдөг, сэлгэдэг. 200 орчим километр нүүдэллэдэг ийм л байсан.

Өнөөдөр ямар ч зохицуулалтгүй. Ноолуур үнэтэй бол ямааг өсгөнө. Мал махны хойноос, тооны хойноос хөөцөлддөг. Одоо сум болгонд хэдэн зуун мянгалууд бий болчихсон. Нэг л

залаатай, ийм л малгайтай, ийм л бэлчээрийн мал аж ахуй явж байгаа.

Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь нийгэм, эдийн засгийн болон бүхий л салбарт өөрчлөлт гарах ёстой.

Зарим засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг бид эргэж харах ёстой.

Хоорондоо 20-иос 30 км-ийн таталцалтай сумдыг заавал засаг захиргааны бие даасан нэгж цааш цашид байлгах ёстой юм уу, үгүй юм уу. Сумдын удирдлагууд нь аймгийн төв дээр байдаг тийм ээ, ийм хүртэл эргэж харах асуудлууд бий гэдгийг зүгээр хэлье.

Энэ удаа бид Үндсэн хуулийн цэц, Их Хурлын тогтоолын хүрээнд энэ төсөл өргөн баригдаж байгаа гэдгийг дахиж хэлье.

**П.Анужин:** Ц.Идэрбат гишүүн тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Тодруулах хоёр асуулт байгаа юм.

Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулаад улс төрийн суурь томоохон реформын өөрчлөлт хийе гээд. Түүний нэг нь Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль.

Их Хурлын гишүүн болохын төлөө 400, 500 сая төгрөг зарцуулаад. Зарим нь тэрбум төгрөг зарцуулаад авч байгаа сарын цалин нь 2 сая гаран төгрөг гар дээрээ аваад байдаг. Энэ хоёрын ялгавар энэ тэрийг тооцох юм бол яагаад ийшээ зүтгээд байдаг юм бэ гэдгийн шалтгааныг иргэд ойлгохгүй байгаа байхгүй юу. Тийм.

Тэгэхээр энэ бол одоо бас энэ Сонгуулийн хууль, Улс төрийн намын хуулийг цогцоор нь өөрчлөх том шалтгаан болов уу гэж. Үндсэн хуультай шууд холбоотой асуудлууд учраас би тодруулж байгаа юм.

Хоёрдугаарт, одоо ингээд 152-ыг мэдээж Хэнтий аймаг дээр очоод уулзахад ард иргэд ч дэмжихгүй байгаа юм.

Наадах чинь арай хэтэрнэ. Надад хэлсэн хамгийн максимум тоо нь 120 байхгүй юу. 100-аас хэтрүүлж болохгүй гээд л Хэрлэн сум дээр, Өмнөдэлгэр дээр 108 гээд л хэлж байх жишээтэй.

Тэгэхээр бид судлаачдын хэлсэн нөгөө тоонуудыг бид иргэд ингэж байна гээд багасгаад байвал Үндсэн хуулийн өөрчлөлт хийгээд тоо нэмэх, тэндээс гарах ач холбогдол гэдэг юмнууд чинь энэ тоотойгоо шууд уялдаад. Сүүлдээ бүр нөгөө судлаачдын хүлээж байсан үр дүн гарахгүй.

Ёстой харин явж явж тэгээд 76-г хэдхэн хүнээр нэмээд. Ёстой нөгөө даргын тоо нэмсэн юм шиг. Нөгөө кнопны үнэ цэнэ. Түүгээрээ дамжуулдаг янз янзын юмнууд нь хэвээрээ байх тийм эрсдэл рүү бас орчих байх.

Одоо Байнгын хороон дээр нөгөө журмаараа 152 гэдэг дээрээ санал хураах юм байна гэж би ойлгож байгаа.

Харин өнөөдөр улс төрийн намууд. Энэ чинь ганц Ардын нам яриад байгаа биш Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам гээд тоон дээр яриад 126 гэсэн тоо орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр маргаашаас энэ 126 гэдэг тоо яг Байнгын хороод руу орж ирэх юм байна л даа.

Тэгэхээр ер нь судлаачид тоог иргэд ингээд эсэргүүцэж байгаа учраас багасгаад байна гэж байгаа. Энэ нь судлаачдын хүсэн хүлээж байсан үр дүн нь 126 гэдгээс юм уу, эсвэл одоо бүр.../минут дуусав/

**П.Анужин:** 3 номерын микрофонд хариулъя. Өөрийгөө танилцуулаад хариулаарай.

**Н.Ууганбаатар:** Сайн байна уу? Н.Ууганбаатар гэдэг. МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор хүн байна. Гишүүний асуултад хариулъя.

Гишүүн сая их зөв ажиглалт хийж байна. Их зөв дүгнэлт хийж байна гэж бодож байна. 126 гэдэг тоо судалгаагаар гарч ирээгүй. Түрүүн Х.Нямбаатар гишүүн ч хэлж байх шиг байна.

Энэ бол зөвшилцлөөр гарч ирж байгаа юм байна гэж ойлгож байна. Бид нарын тооцоогоор 150, 138 гэсэн ийм хоёр тоотой орж ирсэн. Өнгөрсөн удаа.

Шинжлэх ухаанд нэг бодлого олон хариутай байдаггүй юм.

Тийм учраас бид хариугаа өгсөн. Тэгээд үлдсэн нь улс төрийн л шийдэл болж байх шиг байна.

Дахиад хоёр асуудал байсан. Нөгөөдөх нь 50, 50 гэсэн ийм хоёр юутай орж ирсэн.

Тэгээд нэг сонирхолтой ажиглалт юу байна вэ гэхээр 152 бол тооны тухай асуудал. 50, 50 бол чанарын тухай асуудал. Хүн тоон дээр дүгнэлт өгөхдөө тийм сайн биш ээ гэдгийг шинжлэх ухаан



бас нотолчхоод байгаа. Хүн чанар дээр дүгнэлт өгөхдөө илүү сайн байдаг.

Тийм учраас гадаадад, юу гэдэг юм, хөгжсөн газар яадаг вэ гэхээр ард нийтээсээ санал асуухдаа илүү.../минут дуусав/

**П.Анужин:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Надад асуулт алга. Хэд хэдэн саналууд байгаа юм.

Тэгээд сая гишүүд яриад л байна. Тойрогтоо ажилласан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүүтэйгээр нийгмийн асуудал, цалин мөнгөний асуудал, барааны үнийн асуудал гээд.

Манай Нийгмийн бодлогын байнгын хороонд Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байдаг утгаараа ер нь сая Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэх үед дийлэнх олонх гарч байгаа асуудал энэ цалин мөнгөний асуудал байна.

Тийм учраас ямар ч гэсэн өчигдөр бүлэг дээр гишүүд яриад орон нутгийн ард иргэдийн тавьж байгаа санал, хүсэлтийг хэлэлцээд Засгийн газар тодорхой арга хэмжээ авах юм шиг байна. Авахдаа бас учир начиртай бодох хэрэгтэй байна.

Цалин мөнгө нэмэгдүүлэх хэмжээнд асуудал яригдах бололцоо боломж хомс байгаа шүү дээ. Сая ярьж байна. Тэр ялгаа зөрүүг арилгах хэмжээнд л асуудал ярина гэж.

Тэгээд үүний чинь сургаар, зөрүүг арилгахыг дагаад бараа, бүтээгдэхүүний үнэ ханш өсдөг шүү.

Тийм учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд энэ дээр онцгой анхаарал хандуулж тэр Засгийн газар харьяа агентлаг, тэр гар хөлөө хөдөлгөж, тэр өрсөлдөөний зохицуулах газартайгаа ярьж өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг ахиж нэмэгдүүлэхгүй байх тал дээр, цалин мөнгөний ялгааг арилгах сургаар ийм сөрөг үзэгдэл гарахгүй байх тал дээр онцгой анхаарал хандуулж ажиллах тал дээр.

Одоо ингээд төсвийн хүрээний мэдэгдэл өргөн баригдчихаад явж байна. Хэлэлцэгдээд явж байна. Энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хороо, манай байнгын хорооноос Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээг дагасан энэ асуудал дээр онцгой анхаарал хандуулж юу гэдэг юм шаардлагатай бол тогтоол гаргасан ч яах вэ дээ.

Хэрвээ энэ сургаар ахиад үнэ ханш нэмэгдвэл энэ чинь бараг нэмснээс өөрцгүй, ялгаагүй ямар ч үр дүн гарахгүй ийм арга хэмжээ болж хувирна.

Тийм учраас энэ дээр онцгой анхаарал хандуулж ажиллаач ээ гэдгийг сая сайд бас гараад явчих шиг боллоо. Энэ тал дээр онцгой анхаарал хандуулж Нийгмийн бодлогын байнгын хороо анхаарах хэрэгтэй байна.

Нөгөө талаар Нийгмийн бодлогын байнгын хороотой холбоотой асуудал энэ нийгмийн даатгалын багц хуулийг чинь онцгой их асууж байна. Байнгын хорооны дарга аа.

Тийм учраас Нийгмийн бодлогын байнгын хороо энэ төсвийн хүрээний мэдэгдэл өргөн барьчихсан байна. Хүрээний зааг юмнууд хязгаарууд ороод ирчихсэн байна. Энэ өргөн баригдсан төсвийн хүрээний мэдэгдэл тэгвэл бид

нарын өргөн барьчхаад байгаа нийгмийн даатгалын багц хууль, нөгөө олон асуудлуудыг шийднэ гээд бүгдийг нь тусгачихсан. Тэрний чинь цаана дандаа төсөв санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй. Энэ нь яг энэ өргөн баригдсан төсвийн хүрээний мэдэгдэлд сууж уу, үгүй юу? Энд хэн анализ хийж байна. Энэ төсөв тооцоон дээр нь хэн сууж байна, харж байна. Хэдий хэмжээний нэмэгдүүлэхээр.

Нөгөө хуулийн чинь нийцэл зохицол нь хаанаа байна. Сангийн яам юу гэж үзэж байгаа юм. Энэ болгон дээр одоо ярихгүй бол 9 сард төсөв өргөн баригдсан хойно оройтсон бороо болно шүү.

Тийм учраас яг энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр нийгмийн даатгалын багц хуультай холбоотойгоор энэ тэтгэврийн зөрүүг арилгах, нөгөө 5, 7 жилийн асуудал гээд үүнийг чинь асууж байгаа улсууд маш олон байна.

Нөгөө талаар манай Байнгын хороотой холбоотой асуудал эмийн асуудал. Бас л асууж байна. Авч байгаа 400 мянга, 500 мянган тэтгэврийнхээ 100 гаруй мянгыг доор хаяж эмэнд өгч байна.

Бид энэ асуудлыг яриад тендерийн хууль дээр эмийг бага үнийн зохицуулалтаар биш чанарыг урьтал болгодог. Тендерийг үнэлэхдээ энэ ийм зарчмыг оруулж байгаа. Энэ бол одоо бас том дэвшил гаргана гэж үзэж байгаа.

Нөгөө талаар энэ эм, эмнэлгийн хэрэгслийн хууль чинь хаана явна вэ? Нөгөө түр хороо нэр зүүсэн байдалтай замын дундаас хаяад явчихсан, хугацаа нь дуусчихсан. Одоо ахиад сунгах уу, яах вэ?

Тийм учраас энэ асуудлууд манай Нийгмийн бодлогын байнгын хороонд

харьяалалтай асуудлууд гарсан учраас би энэ дээр өнөөдөр хэлж байгаа юм.

Тийм учраас Байнгын хорооны дарга бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт яах вэ. 152 бол хэт олон байна. Бууруул гэдэг дийлэнх олон санал нь ингэж гарсан. Тогтолцооны хувьд сонгуулийн холимог тогтолцоогоо хийгээд явах нь зөв гэж ингэж гарсан.

Энэ саналыг хүлээж аваад ямар ч гэсэн 152 чинь тодорхой хэмжээнд буурах юм шиг байна. Тийм.

Хажуугаар нь ард иргэдийг бухимдуулж байгаа, ард иргэдийн тулгамдсан асуудал энэ асуудал.

Тийм учраас энэ асуудлууд манай Байнгын хороонд харьяалалтай учраас нөгөө өргөн баригдсан хуулиуд маань Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийнхөө дараа анхаарал хандуулж, энэ дээрээ ач холбогдол өгч суухгүй бол, төсөв дээрээ анхаарахгүй бол ингээд Байнгын хороо төсвийг нь Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам ингээд л нэг аргалж байгаад л төсөв даахгүй, ачаалал даахгүй гэж байгаад л, бөөн зовлон ярьж байгаад л.

Бүрэн эрхийн хугацаанд нэг байгаа дээрээ нэг нийгмийн даатгалын багц хуулийг хэдүүлээ нэг. Үлдэх гол хууль чинь энэ л юм байна гэж би харж байгаа. Нэг хүнд ч гэсэн, нэг ахмадад ч гэсэн нэг наалдацтай хэрэгтэй нэг хууль баталчих юм сан л гэж ингэж бодож байна.

Тийм учраас энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хороо онцгой анхаарал хандуулж өгөөч ээ л гэж би хүсэж байна. Өөр хэлэх юм алга.

**П.Анужин:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Х.Булгантуяа сайд. Асуултад хариулъя гишүүд ээ чимээгүй байж байхгүй юу.

Түрүүн Х.Булгантуяа сайд орж ирээд буцаад гарчихлаа. Сайдыг орж ирэхээр хэлмээр байна.

Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой санал хэлж байгаа бүх гишүүдийн амнаас нийгмийн хамгаалалттай, цалин тэтгэмжтэй холбоотой, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар асуудлууд гарч ирээд байгаа юм.

Тийм учраас түрүүнээс хойш энэ сайдыг байлцуулаач ээ гэдэг энэ үүргийг өгч байгаа юм.

Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж дуусангуут манай Нийгмийн бодлогын байнгын хороон дээр цалин, тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баримтлах бодлогыг бид сонсье гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа юм. Тийм.

Бид Сангийн яамны төсвийн хүрээний мэдэгдлийг Нийгмийн бодлогын байнгын хороо сая Ц.Сандаг-Очир гишүүний асууснаар тодруулсан.

Манай нийгмийн даатгалын багц хуульд өөрчлөлтөд нэн шаардлагатай 1.1 их наяд төгрөгийн асуудал байгаа юм. Энэ асуудал төсвийн хүрээний мэдэгдэлд суугаагүй байсан. Санал өгөөгүй гэж.

Тэгэхээр бид төсвийн хүрээний мэдэгдлээ яг Ц.Сандаг-Очир гишүүний хэлсэнчлэн нийгмийн даатгалынхаа багц хуультай уях тал дээр Нийгмийн бодлогын байнгын хороо ажиллана. Үүнийг хэлэлцүүлгийн үед бид энэ саналуудаа аваад ингээд явна. Ард

иргэдийн дунд хамгийн их хүлээлттэй байгаа хууль бол энэ багц хууль гэдгийг бүрэн ойлгож байгаа.

Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдэлтэй бид уялдуулах тал дээр ажиллаж байгаа. Орж тусаагүй байна лээ. Энэ өөрчлөлтүүд гэдгийг маш тодорхой хэлчихье.

Төсвийн хүрээний мэдэгдэлтэй. Үндсэн хуультай холбоогүй. Төсвийн хүрээний мэдэгдлийг нийгмийн даатгалынхаа багц хуультай уялдуулж байгаа юм уу. Төсвийн хүрээний мэдэгдэл чинь уялдаж орж ирж байгаа юм уу гэдэг.

Нийгмийн даатгалын багц хуулийг шийдэхэд, тэтгэврийн зөрүүг арилгахад шаардлагатай мөнгө төсөв байхгүй юу. Энэ мөнгө маань уялдаж байгаа юм уу гэдэг асуулт байсан. Тийм үү? Ц.Сандаг-Очир гишүүн ээ. Тийм.

Тэгээд энэ маань өөрөө тусгаагүй байлаа гэдгийг Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс үүнийг бид асуусан юм. Тэгсэн ийм зүйл хэлсэн юм. Ц.Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ер нь өнөөдрийн дэгийн дагуу бид хэлэлцэж байгаа асуудал. Мэдээж ард иргэдийн зүгээс эдгээр асуудлууд хөндөгдсөн. Үүнийг үгүйсгэхгүй. Гэхдээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэйгөө холбоотой гишүүд асуултаа илүү тодорхой дэлгэрэнгүй асууя.

**Ц.Сандаг-Очир:** Тийм. Х.Нямбаатар сайд аа, би тантай санал нэг байгаа.

Том эдийн засгаа тэлж байж, өсгөж байж цаашдаа системээ, цалингийнхаа системийг, нийгмийн

даатгалынхаа системийг ярих, нэмэх асуудал үүснэ.

Бид сая иргэдэд тэгж л ярьсан. Бид энэ бүрэн эрхийн хугацааны 50 хувь нь анх сонгуулиа масктай л хийсэн хасах 4 хувийн эдийн засагтай л байсан. Хасах эдийн засаг 4 хувьтай байхад бид юун цалин мөнгө нэмэгдүүлэх асуудал ярих бололцоо боломж үнэхээр хомс байсан.

Гэтэл одоо өнгөрсөн 2 жилийн хугацааны 2 гаран жилийн хугацаанд авсан арга хэмжээний хүрээнд жоохон эдийн засаг макро түвшиндээ сайжраад, үзүүлэлтүүд нь сайжраад нэмэгдэж байгаа. Ард иргэдийн даалгавар хүнд байгаа. Бараг нэг хоногийн өмнө ч гэсэн цалин мөнгөө нэмэгдүүл гэдэг шаардлагыг тавьж байгаа.

Тийм учраас том эдийн засгаа тэлж, өсгөж, сайжруулж, үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулж байж цалин мөнгө нэмэгдүүлэх асуудал үүснэ шүү л гэж ард иргэдэд тайлбарлаж байгаа. Гэхдээ ард иргэдийн амьдрал амаргүй байна л гэдгийг хэлж байгаа.

Тийм учраас ямар ч байсан Засгийн газар хүндхэн даалгаврын доор ажиллаж байгаа. Жоохон амьсгаа авахдаа, өрөө жоохон барагдуулж байна. Жоохон орлогоо нэмэгдүүлж байна. Бололцоо боломж байдаг бол жоохон тогтворжуулаад, жоохон хуримтлал бий болгоод ингэж ажиллавал уг нь том эдийн засгийн утгаараа сайн. Гэхдээ үүнийг хүлээхгүй байна. Ард иргэд.

Өнөө маргаашгүй цалин мөнгөө нэм гэдэг ийм л шаардлагыг ярьж байгаа учраас бид ард иргэдийн тавьж байгаа санал хүсэлтийг бид энд уламжилж ярьж хэлэх нь бид нарын үүрэг учраас ярьж байгаа гэдгийг ойлгож байна.

Нөгөө талаар би эдийн засгийн том үзүүлэлтүүд сайжраад эндээ баяртай байгаа. Гэхдээ бид баярлах болоогүй байна. Баярлах болоогүй. Үүний төлөө ажиллах ёстой. Бүр ч орлогоо нэмэгдүүлэх, бааз сууриа нэмэгдүүлэх, энэ авлига, хээл хахуультай тэмцэх ажлаа үргэлжлүүлэх гээд.

Засгийн газрын таны хэрэгжүүлж байгаа “Таван Ш” ажиллагааг үнэхээр ард иргэд ам сайтай байна лээ. Энгийн бөгөөд авлига хээл хахуультай.../минут дуусав/

**П.Анужин:** Дамбын Д.Батлут гишүүн асуулт асууя.

**Д.Батлут:** Өдрийн мэнд хүргэе.

Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид ард иргэдтэйгээ уулзаад ярьсан асуудлууд тавигдсан учраас ярих л ёстой л доо. П.Анужин дарга аа. Тэр утгаараа бид ярьж байгаа.

Тэгэхээр үүнийг хориглох шаардлагагүй болов уу гэж бодож байна.

Бид Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг иргэдэд танилцуулж явсан. Миний тухайд 2 мянга орчим иргэнтэй уулзаж санал хүсэлтийг нь авсан. Иргэдийн хувьд үнэхээр л бусад гишүүд ч хэлж байна. Амьдрал хүнд байгаа. Цалин мөнгө бага байна. Амьжиргааны өртөг өндөр байгаа. Юмны үнэ өсчихсөн асуудал ярьж байгаа. Хүүхдийн мөнгийг ялгавартай олгож байгаа асуудлыг ярьж байгаа.

Тэгээд бид ингээд л алдаа гаргаад тэрийгээ ахиад засах гээд байгаа дүр зураг л харагдаж байна л даа.

Тэгэхээр бид урьд нь нэг тэтгэвэр нэмсэн. Тэр тэтгэвэр өнөөдөр яг

амьдралд, ард иргэдэд, ахмадуудын амьдралд нь наалдацтай нэмэгдэл болсон уу гэж асуухад бүгд үгүй гэж байгаа байхгүй юу.

Яасан гэхээр дагаад юмны үнэ өсгөчихсөн.

Монгол Улсын Засгийн газар сайн ажиллаж байгаа. Бас. Далд эдийн засгийг тодорхой хэмжээгээр ил болгох. Тэр болохгүй байгаа зүйлүүдийг засаж залруулах.

Тухайлах юм бол уурхайн аман дээрээс нүүрсийг зарж байсан бол болиод Улсын Их Хурлаас баталсан Биржийн тухай хуулиар биржээр борлуулаад эхэлсэн нь өөрөө эдийн засгийн эргэлтийг бий болгож байгаа тодорхой хэмжээний орлого Монгол Улсад төвлөрүүлэх боломжийг бүрдүүлж байгаа гээд.

Тэгээд бид үүгээр цалин урамшуулал ч гэдэг юм уу, бусад тэтгэврийн зөрүү бүгдийг нь арилгая. Ингэж нэмэгдүүлье гэхээр гол асуудлаа шийдээгүй байгаа дүр зураг харагдаад байгаа юм. Тэр нь нөгөө юмны үнийн өсөлт.

Тэгэхээр Засгийн газар юмны үнийн өсөлт дээр ер нь судалгаа хийж үзсэн юм уу? Юмны үнийн өсөлтийг хэрхэн зохицуулах ёстой юм бэ?

Бид цалингийн зөрүүг арилгана ч гэдэг юм уу, эсвэл доод түвшнийг дээшлүүлнэ, тэтгэврийг нэмэгдүүлнэ гэдэг. Нэмэгдүүлдэг. Дагаад юмны үнэ өсчих юм бол эргээд хувь хүн талдаа ямар ч наалдацгүй болчихоод байгаа юм л даа.

Тэгэхээр бид тэр юмны үнэ өсөөд байгаа үндсэн шалтгаануудыг судалж

түүнтэй холбоотой арга хэмжээг авахгүй бол ерөөсөө болохгүй.

Зүгээр бодоод үзье л дээ. Бид Эрээнээс бараа, бүтээгдэхүүн авч байна. Тээвэрлэлт, дахин тээвэрлэлт, тэгээд бөөнддөг, жижиглэнгээр худалдаалдаг хүмүүс авдаг ч гэх юм уу. Магадгүй нөгөө хэрэглэгч дээрээ очихдоо 3-аас 4 шат дамжлага дамжиж ирээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ мэтчилнээр судалгаа хийгээд, үнийн өсөлтийг барихын тулд ямар арга хэмжээ авах юм. Засгийн газар өөрөө. Үнийн өсөлтийг байхгүй болгож байж цалин тэтгэвэртэй холбоотой асуудал дээр хөндөхгүй болохоор бас яг үнэндээ хувь хүн тал дээр наалдацгүй болчихоод байгаа юм. Тэгээд энэ дээр цаашдаа яах вэ гэдэг дээр нэг хариулт өгөөч ээ.

Хүүхдийн мөнгөний асуудал. Анхнаасаа л ярьсан. Хүүхдийг ялгаварлаж байгаа, хүний эрхийн зөрчил үүсэж байгаа гээд л.

Өнөөдөр Монгол Улсын нийт хүүхдийн 9 хувьд нь мөнгө олгохгүй гэж байгаа боловч зарим нэг газруудаар өөр үр дүн харагдаж байна.

Тухайлах юм бол манай Орхон аймагт. Орхон аймагт хүүхдийн мөнгө авч байсан хүүхдүүдийн 23 хувь нь хасагдсан.

Тэгээд тэр нь болохоор дандаа ажил хийж, баялаг бүтээж байгаа хүмүүсийн хүүхдүүд байхгүй юу.

Тэгэхээр ажил хийж, баялаг бүтээж байгаагаараа бас тэр хүмүүс буруудаад байгаа юм шиг нөхцөл байдал харагдаж байгаа юм. Би албан байгууллагуудаар уулзалт хийхэд

ерөөсөө л ийм л юм ярьж байгаа юм. Бид ажил хийж, татвараа төлж, мөнгө өгснөөрөө буруу болчихоод байгаа юм уу. Яагаад бидний хүүхдүүдийг ялгаварлаад хасаад байгаа юм бэ гэдэг асуудал ярьж байгаа юм.

Сая сайдын мэдээллээр хүүхдийн мөнгийг 100 хувь олгохоор болж байгаа гэж байгаа юм шиг байна. Үүнийг бид олгох хэрэгтэй. Тэгэхдээ урьд нь олгоогүй байгаа хэмжээгээ нөхөж олох хэрэгтэй. Олгоогүй байсан хүүхдүүдийнхээ урьд нь олгоогүй саруудаар.

Цаашлаад бид хүүхдийн мөнгө чинь халамжийн мөнгө юм уу, эсвэл яг хүүхдийн хөгжил зарцуулах мөнгө байх ёстой юм уу. Үүнийгээ тодотгож хууль эрх зүйн зохицуулалтуудыг нь хийж өгөх ёстой. Ингэхгүйгээр цаашаа тийм янз бүрийн улс төрийн кризист орох, улс төрийн нөхцөл байдлаар буруу шийдэл гаргах нөхцөл байдлууд үүсгэчих вий. Ирээдүй дахиад.

Тэгэхээр энэ дээр цаашдаа яана гэж харж байгаа юм бэ гэдэг дээр хариулт өгөөч ээ.

Ард иргэдтэй уулзаж явахад Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг яг тоо талаас нь. Тухайлах юм бол 152 гэдэг тоон дээр эсрэг байр суурьтай байгаа.

Тогтолцооны өөрчлөлтийг дэмжиж байгаа. Бид нэлээн л ярьсан. Дэмжиж байгаа. Тэгэхдээ 152 бол биш юмаа гэж. Тэгээд одоо 126 гэдэг дээр намуудын түвшинд зөвшилцсөн гэж ойлголоо.

Иргэд бүр 76-аараа байя. Тогтолцооны өөрчлөлт хийх юм бол 108 болгоё. Зарим нэг нь 76-аас ч бага байх

хэрэгтэй. Ардын Их Хурлын социалист нийгмийн үед Улс төрийн товчоо гээд цөөхөн хүний бүрэлдэхүүнтэй явж байсан шүү дээ гээд л хөгшчүүд ярьж байх жишээтэй.

Тэгэхээр 126 гэдэг маань ямар үндэслэлээр намууд маань зөвшилцсөн юм бол оо? Тийм ээ. Яах вэ Үндсэн хуулийн тогтолцооны өөрчлөлттэй холбоотойг дэмжиж байгаа. Тэгэхдээ 152 дээр иргэд эсрэг байр суурьтай байгаа. Иргэд 108 болгооч, 99 болгооч гэдэг саналууд хэлж байгаа.

Тэгэхээр 126 гэдэг нь яг зөвшилцөхдөө ямар утга агуулгаар энэ тоог гаргаж ирж зөвшилцөх юм бол гэдэг дээр нэг хариулт өгөөч ээ. Баярлалаа.

**П.Анужин:** Д.Батлут гишүүний асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хариулна.

Гэхдээ тэр сүүлийн асуултад хариулсан. Энэ тооны тоотой холбоотой. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэйгөө холбоотой асуудлуудыг хариулаад. Нийгмийн бодлоготой холбоотой, энэ цалин тэтгэмжтэй холбоотой асуудлуудыг түрүүн та өөрийнхөө хэмжээнд хариулсан.

Би ахиад хэлье. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэгдсэний дараа бид нэн яаралтайгаар иргэдээс ирсэн санал, гомдол тийм ээ, цалин, тэтгэмжийн асуудал, нийгмийн даатгалын багц хуулийн асуудал, эдгээр бүх асуудлуудыг бид Засгийн газрын мэдээллийг Нийгмийн бодлогын байнгын хороонд хамгийн түрүүнд сонсоно гэсэн чиглэлийг өгсөн байгаа.

Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Хишгээгийн

Нямбаатар гишүүн гишүүдийн тоог нэмэх тал дээр, тооны асуудлаар хариулт өгнө.

**Х.Нямбаатар:** Тийм. Би товчхон хариулчихъя.

**П.Анужин:** Би өөрөө адилхан тойргоос сонгогдсон гишүүн.

Тийм учраас анхнаасаа би дэмжиж хариулаад байсан. Тэр ч үүднээсээ би Х.Булгантуяа салбарын сайдыг өчнөөн удаа би дуудуулж байна. Үр дүнтэй хариулт авахыг хүсэж байна. Тийм ээ.

Х.Нямбаатар сайд өөрийнхөө харилцаа холбоотой зүйлээ хариулна. Өөрийнхөө хүрээнд түрүүн тодорхой хариулсан гэж үзэж байгаа.

Х.Булгантуяа сайдыг ахиад дуудуулна уу.

**Х.Нямбаатар:** Би Д.Батлут гишүүний асуултад товчхон хариулахыг хичээе.

Тооцоо гаргаж үзсэн. Хүүхдийн мөнгөний нэмэгдэл 100 хувь олгох, цалин тэтгэврийн зөрүүг арилгах гээд.

Эд нар дээр ойролцоогоор энэ оны 2 дугаар хагаст шаардагдах санхүүжилт нь 650 тэрбум төгрөг. Ирэх жил улсын төсөв дээр ирэх ачаалал нь 1.3 их наяд байхаар тооцож байгаа юм билээ. Тийм.

Тэгэхээр ийм байдлаар төсвийн төсөл боловсруулагдаж явж байгаа. Энэ 6 сардаа энэ асуудлыг хэлэлцье гэсэн агуулгатай байгаа.

Тэгээд л бид нарын яг очоод тулж байгаа юм нь ишиг ухнын зөвлөнг мэдэхгүй гэдгийн л үлгэр болж байгаа юм л даа. Эдийн засгийн өөрийн багтаамж.

Тэгэхээр бид цаашид эдийн засгийн багтаамжаа нэмэгдүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдийг явуулж байж бидэнд илүү боломж гарч ирнэ.

Бид эдийн засгаа солонгоруулья гээд энэ жил аялал жуулчлалыг дэмжих жил гээд зарлаж байна. Сайн эерэг мэдээнүүд байна. Энэ зуны бүх билетүүд үндсэндээ зарагдчихаад байна гэдэг.

Тэгээд Монгол Улсын аялал жуулчлалын байгууллагууд үүнийг яг бүрэн хүлээж авч чадах уу? Энэ бол нэг л төрөл хэлбэр. Жоохон ч гэсэн өнгө нэмж байгаа.

Хоёрдугаарт, өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас намайг ажлын хэсгийг ахалж ажилла. “АРЕВА”-тай байгуулах тогтвортой байдлын гэрээний төсөл боловсруулж танилцуулах бэлтгэл ажлыг ханга гээд. Энэ бас л эдийн засагтаа нөгөө бүүстер тун залгая гэдэг ийм л бодлогууд явагдаж байгаа.

Тэгээд энэ бол ойрын үедээ хэдүүлээ бас энэ тал дээр ахиц гаргана гэж бодож байгаа.

Сая бид 3 дугаар сард Оюу Толгойн гүний уурхайг нээсэн. 2025 оны төгсгөл гэхэд одоогийн борлуулалтын хувь хэмжээ 2.5-аас 3 дахин нэмэгдэх гэх мэт ийм эерэг өөдрөг зүйлүүд бидний өмнө байгаа гэдгийг хэлье.

Тэгээд энэ дээр Х.Булгантуяа сайд нэмж орж ирж хариулах байх.

Тооны хувьд. Тийм ээ. Хүн болгон яг адил зүйл ярихгүй байгаа. Би тойргийнхоо иргэд сонгогчидтой 2, 3 сард нэг удаа уулзчихдаг гишүүний хувьд зарим нь загнана, зарим нь хэлнэ,

шүүмжилнэ, зарим нь магтана. Янз бүр л байгаа. Бидний хийсэн уулзалтын статистик дүнг бид нэгтгэж өгсөн.

Нийт үг хэлсэн хүмүүсийн 90 гаруй хувь нь одоо тэгээд үнэхээр та хэд эрдэмтэн судлаачидтай яриад нэмье гэж байгаа бол нэмэх нь зөв зүйтэй байх. Иргэд бид яг нарийн тооцоо судалгаа хийгээгүй. 152 чинь арай их юм биш үү л гэдэг ийм л дүн гарсан.

Тэгээд энэ хүрээнд өчигдөр манай намын бүлэг дээр 126 гэдэг асуудал яригдаад дэмжигдсэн. Ардчилсан намтай хийх зөвшилцлийн ажлын хэсгийнхэн бас уулзаад танай тавьсан 40, 60-ын харьцаатай байх гэдэг санал дээр бид очлоо.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зөвшилцөл дунд хийгдэх ёстой гэдэг агуулгаараа 126 гэдэг бол нөгөө нутаг дэвсгэрийн төлөөллийн 76, түүн дээр нэмэх нь 50 буюу 39.5, 60.5 гэсэн ийм пропорцтой үндсэндээ гарч ирж байгаа. Ийм зөвшилцлийн ажил явж байгаа.

Тэгээд агуулга нь мэдээж хэрэг таны хэлж байгаа хэдүүлээ нутаг дэвсгэрийн одоогийн хадгалж ирж байгаа уламжлалт тойргийн тогтолцоогоо хадгалъя. Түүн дээр нь нэмэгдээд нийгмийн бүлэг, сегментүүдийн төлөөллийг жагсаалтаар нэр дэвших энэ боломжуудыг нээхэд энэ хэмжээний тоо байх боломжтой.

Энэ утгаараа том бодлого, нийгмийн бүлгүүдийн эрх ашгийг хамгаалах, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах энэ чиглэлийн хүний хөгжлийг хөгжүүлэх тал дээр төрийн бодлого чиглэгдэх боломжтой статистик тоо юм болов уу гэдэг агуулгаар бид явж байгаа.

Дэгийн хувьд маргааш Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хоёрдугаар хэлэлцүүлэг дээр энэ асуудал зарчмын зөрүүтэй санал хураагдана. Тэгж байж гуравдугаар хэлэлцүүлэг дээр уг асуудал дахиж яригдах боломжтой.

Хэрэв хоёр дээр хөндөгдөөгүй тохиолдолд гурав дээр уг асуудал яригдахгүйгээр явчих асуудал байгаа учраас сая бүлгийн удирдлагуудын түвшинд ийм яриа болсон.

**П.Анужин:** Х.Булгантуяа сайд орж ирлээ. Х.Булгантуяа сайд аа. Түүрүүнээс хойш бараг 7, 8 гишүүд асуулт асуулаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор.

Бүгд тойрог дээрээ ажиллаад ирсэн. Ард иргэдийнхээ саналыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор аваад ирсэн.

Ерөөсөө тойрог дээр ярьж байгаа зүйл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүүтэйгээр ард иргэдийн амьжиргааны түвшин, цалин, тэтгэмжийн асуудал. Энэ нэмэгдэх юм уу, яах юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэйгөө хэрхэн холбогдож байгаа юм. Үүнийг цалин, тэтгэмж нэмэхээс өмнө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яриад байгаа нь ямар учиртай юм гэсэн ийм асуултуудыг хэлсэн учраас бүх гишүүд маань энэ асуултыг асууж байгаа юм.

Тэгэхээр та энэ тал дээр бүх гишүүдийн асуусан асуулт дээр нэгтгээд маш тодорхой хариулт өгнө үү. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж дууссаны дараа Нийгмийн бодлогын байнгын хороон дээр цалин, тэтгэмжийг



нэмэгдүүлэх талаар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тал дээр тус яамны Засгийн газрын бодлого, байр суурийг сонсох чиглэл өгсөн байгаа.

Ингээд та асуултад хариулна уу.

**Х.Булгантуяа:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой би бас Баянзүрх дүүрэг дээр иргэдтэй уулзсан. Бас л ерөөсөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүүтэйгээр өнөөдөр иргэдийн дунд цалингийн асуудал, төрийн албан хаагчдын хувьд цалингийн асуудал, ахмадуудын хувьд тэтгэврийн асуудал, эмэгтэйчүүд, ээж нарын хувьд хүүхдийн мөнгөний асуудлыг л хамгийн илүүтэйгээр ярьж байна.

Тэгээд өнөөдөр хэдийгээр тэтгэвэр 2022 онд нэмэгдсэн ч гэсэндээ ахиад бараа, материалын үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэн учраас бид нарын амьдралд хаанаа ч хүрэлцэхгүй байна гээд.

Би ажлаа аваад яг нэг сар болж байна. Энэ хугацаанд ерөөсөө л нэгдүгээрт төрийн албан хаагчдын цалин хэтэрхий ялгавартай байгаа талаар иргэдээс ирсэн гомдлуудыг нэгтгээд ингээд аваад үзэхэд яг үнэхээр тийм байна. Зарим төрийн албан хаагчдын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс арай л бага зэрэг илүү. Нийгмийн даатгалын шимтгэл татвараа төлөх юм бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ч бага болчихоор. Тэтгэврийн тэтгэврээс ч бага цалинтай. Гар дээрээ авч байгаа нь.

Ийм төрийн албан хаагчид байгаад байгаа учраас нэгдүгээрт өнөөдөр Засгийн газрын хурлын дараагаар сая мэдээлэл хийлээ.

Төрийн үйлчилгээ, энэ дотроо соёл, биеийн тамир, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг нэн түрүүнд нэмэхгүй бол хамгийн доод цалинтай байгаад байна.

Хоёрдугаарт, ер нь цаашид Төрийн албан хаагчдын хэт хоорондоо зөрүүтэй ялгааг бид арилгах ёстой.

Гуравдугаарт, бусад холбогдох хуулиудаар төрийн албан хаагчдын цалинг ялгаатай тогтоодог байдлыг бид ер нь цаашдаа болиулах ёстой.

Үүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нэгдсэн тогтолцоотой, тооцоотойгоор оруулж ирээд Улсын Их Хурлаар төсөв дээр нь тусгаж батлуулаад.

Тэгэхээр Нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороогоор ороод батлагддаг байх тогтолцоо руу орох нь зүйтэй гэж үзэж төсвийн тодотголыг миний ойлгосноор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараагаар Засгийн газраас өргөн барихад энэ цалингийн асуудлыг нэн түрүүнд нэмэхээр, оруулж ирж шийдвэрлэхээр ажиллаж байна.

**П.Анужин:** Д.Батлут гишүүн тодруулж асууя.

**Д.Батлут:** Тэгээд энд ярихгүй бид хаана ярих вэ дээ. Тэгээд ярих л ёстой учраас ярьж байгаа. Дарга болж өгвөл бага коммент хэлээрэй.

Асуух ёстой, үүрэгтэй, эрхтэй учраас асууж байгаа.

Тэгээд би яах вэ, цалин мөнгөний зөрүү арилгах, тэр цалингийн доод түвшнийг дээшлүүлэх, тэтгэврийн зөрүү

арилгах, тэтгэвэр нэмэгдүүлэх гээд асуудлуудыг ойлгож байгаа.

Ер нь ард иргэд ч хүсэж байгаа. Тэгэхдээ бид тэр цалин, тэтгэвэр нэмснээрээ хувь хүний амьдрал дээр ямар нөлөөлөл үзүүлж байгаа вэ гэдгийг тооцохгүйгээр явахаар ерөөсөө болохгүй байгаа байхгүй юу. Урьдын тэтгэврийн нэмэгдэл ерөөсөө хүндээ наалдаагүй. Юмны үнэ өсчихсөн. Дагаад.

Тэгэхээр юмны үнэ өсөөд байгаа учир шалтгааныг тодорхойлж, түүн рүү харсан ямар арга хэмжээ авах гэж байна вэ гэдэг асуултад хариулт авмаар байгаа юм. Үүнийг шийдэхгүйгээр бид цалин, тэтгэврийн зөрүүг арилгаад, нэмэгдүүлээд явна гэвэл яг үндсэндээ урьдынхаа байж байгаа дүр зургаа давтана, урагшгүй шийдвэр болж хувирна.

Тэгэхээр энэ дээр та нэг хариулт өгөөч ээ гэж л хүсэж байна. Энэ их чухал шүү.

Хүүхдийн мөнгөтэй холбоотой асуудал. Тэр дээр бид хуулийг нь өөрчилмөөр байна. Байнгын хороон дарга ч гэсэн энэ дээр анхаараад. Магадгүй Байнгын хорооноос барих ёстой юм уу.

Халамжаараа явах юм уу, эсвэл өөр хөгжлийн мөнгө байх ёстой юм уу энэ өөрөө. Үүний ялгаа зааг нь арилгаж өгөхгүй бол өөрөө улс төрийн шийдвэр болоод дандаа асуудал дагуулж байх нөхцөл байдал үүснэ шүү. Үүнээс хойш. Ийм л зүйлийг хэлмээр байна.

**П.Анужин:** Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Х.Булгантуяа хариулна.

**Х.Булгантуяа:** Өргөн хэрэглээний барааны үнэ өсөж байгаа. Тэр дотроо ялангуяа мах, гурил гээд. Тийм ээ. Энэ

барааны үнийн өсөлт иргэдэд хамгийн хүнд тусаж байна гээд.

Мэдээж энэ үнийн өсөлтийг хэрхэн яаж барих вэ гэдэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам шийднэ гэдэг бол хэцүү л дээ.

Тэгээд үүнтэй холбоотойгоор уг нь Улсын Их Хурлаас бид хууль хүртэл баталсан шүү дээ. Өргөн хэрэглээний барааны үнийг тогтворжуулахад гээд хууль хүртэл баталсан.

Үүнтэй холбоотой төсөв, санхүүжилт хүртэл шийдсэн. Тэгээд үүнийг Төсвийн байнгын хороон дээр, Улсын Их Хурал дээр ер нь энэ хуулийн хэрэгжилтийг нэг сонсьё гэж байх шиг билээ.

Сая иргэдээс ч гэсэн ирж байгаа ерөөсөө гол асуудлууд нь энэ байгаад байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бид нэгдүгээрт саяын цалинг нэмэхэд хамгийн санаа зовж байгаа зүйл нь яг үүнийгээ дагаад инфляц өсчих вий дээ. Инфляц нэг оронтой тоо руу яг орж байгаа энэ цаг үед ахиад инфляц өсчих юм бол бид цалин нэмсний үр нөлөө маш бага болно гэсэн үг.

Тэгээд үүнийг Эдийн засаг, хөгжлийн яам бас тооцоо судалгааг нь гаргаж байгаа юм билээ. Яаж нэмбэл тэр нь инфляц дээр хэрхэн яаж тусах вэ гэдэг. Үүнтэй уялдуулж нэгдүгээрт цалингийн нэмэгдлийг хийх нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа.

Хүүхдийн мөнгийг ч гэсэн мөн адилхан төсвийн тодотголыг хийхэд.

Улсын Их Хурлаас 91 хувиар гэж батлаад төсөв дээр 91 хувьд нь яг

тохирсон хүүхдийн мөнгийг олгочихсон байгаа учраас одоо салбарын сайд өөрөө үүнийг дур мэдэн 100 хувьд олгох боломжгүй болчхоод байгаа юм. Төсвийн хууль зөрчсөн асуудал болно. Засгийн газар.

Тэгэхээр төсвийн тодотголоор үүнийг 100 хувь олгох энэ шийдвэрийг төсвийн тодотголтой уялдуулан гаргах байх гэж бодож байна.

Мэдээж орлого талдаа Сангийн яам эхний хоёр улирлынхаа макро эдийн засаг, орлогынхоо тоог хараадахъя. Түүнтэй уялдуулж л бид төсвийнхөө зарлагыг тооцож.../минут дуусав/

**П.Анужин:** Сая гишүүдийн санал. Бүгд л хэлж байна.

Би ер нь энэ хурал эхлэхээс өмнө ажлын албандаа хэлж байсан юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүү нийгмийн асуудал бас яригдаж таарна шүү гэдгийг хэлж байсан. Тэгээд ярихаас өөр аргагүй.

Тэгэхээр Х.Булгантуяа сайд аа, сая гишүүд хэлж байна. Аваагүй хүмүүс гомдолтой байгаа. Бид төсвийн тодотголоор хуульдаа өөрчлөлт оруулаад өглөө гэхэд аваагүй, өөрсдийгөө хохирсон гэж үзэж байгаа хэсэг байгаад байгаа.

Тэр хохирлыг барагдуулах ажлыг тус яам онцгой анхаарч ажиллахгүй бол иргэдийн гомдол барагдахгүй гэдэг ийм санал байгааг та бас анхаарч ажиллана уу гэж хүсэж байна.

Гишүүд ээ, хуулийн төсөлтэй холбоотойгоор зарчмын зөрүүтэй

саналыг ямар нэгэн гишүүн ирүүлээгүй. Байнгын хороонд.

Тийм учраас одоо санал хураалт явуулна. Бүгдээрээ анхааралтай байгаарай.

Та бичгээр гаргаж өгөөгүй байгаа. Одоо ирээгүй. Одоогоор ирээгүй учраас санал хураалт явуулж болохгүй байхгүй юу. Санал хураалт явуулж байж бид Төрийн байгуулалтын байнгын хороо руу явуулах байсан. Одоо урьдчилж өгөөгүй учраас тань дээр санал хураалгах боломжгүй болчхож байгаа юм.

Санал хураалт явуулна. Гишүүд ээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах талаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтын дүн 84.6 хувиар дэмжигдлээ.

Болоогүй ахиад байгаа. Гишүүд ээ. Дараагийн асуудал байгаа шүү.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар санал хурааж дууслаа.

Дараагийнхаа асуудалд оръё.

*Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн алга байна. Зарчмын зөрөөтэй санал мөн ирээгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Мөн зарчмын зөрөөтэй санал ирээгүй болно.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Мөн зарчмын зөрөөтэй санал ирээгүй.

*Хуралдаан 1 цаг 33 минут үргэлжилж, 13 цаг 48 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Гишүүд болон ажлын хэсэгтээ баярлалаа.

Энэ өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна.